

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ
БУЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: **ӨВА-2024/20-14-ШТА-ГА**



Арвайхээр хот
2024 он


Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор **О.Батжаргал**
Утас: 70323253, цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер Д.Гансүх,
Утас: 70323833, цахим хаяг: Gansukhd@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Хорлоосүрэн,
Утас: 70323108, цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn
Аудитор: Ө.Ринчинмядаг,
Утас: 70323108, цахим хаяг: RinchinmyadagU@audit.gov.mn
Аудитор: П.Норпил,
Утас: 70323108, цахим хаяг: Norpilp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

АГУУЛГА.....	1
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ.....	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	5
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	6
БҮЛЭГ-1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БИШ БАЙНА.....	9
1.1. Хүүхэд хамгааллын бодлого, тогтолцоо нь нийгмийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцээгүй байна.	9
1.1.4 Хүүхэд хамгааллын талаар мөрдөж буй хууль тогтоомж, зарим бодлогын баримт бичиг хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.	9
1.1.6 Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй хөтөлбөрийн оролцогч талуудын үүрэг хариуцлага, оролцоо дутмаг байна.....	10
1.2. Аймгийн ХГБХХГ нь чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан боловч хүний нөөцийн хүртээмж хангалтгүй, мэдээллийн сан бүрэн үүсээгүй байна.	11
1.2.2 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан ч эрх нь зөрчигдсөн хүүхдийг дагнасан үйлчилгээгээр бүрэн хангаж ажилласан эсэхийг бүхэлд нь дүгнэн үзэх боломжгүй байна.....	11
1.2.5 Хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан дутмаг, үйл ажиллагаанд хэрэглэгдэж байсан системүүдийн ашиглалт хаагдсанаас шалтгаалан цахим мэдээллийн сан бүрэн үүсээгүй, зарим мэдээлэл архивлагдаагүй байна.	12
1.2.6 Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад аймгийн ХГБХХГ, сумдад хүний нөөц тогтворгүй, зарим тохиолдолд зайлшгүй нөхцөл байдлаас үүдэлтэй мэргэжлийн бус хүн ажиллуулж байна.....	14
БҮЛЭГ-2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫГ 2019-2021 ОНУУДАД ТООЦОО СУДАЛГААНД ҮНДЭСЛЭЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ ДЭЭД ГАЗРААС ШУУД САНХҮҮЖИЛТ ОЛГОЖ ИРСЭН БОЛ 2022 ОНООС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭР ТӨРӨЛ, АРГА ХЭМЖЭЭГЭЭР НЬ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.....	16
2.1. Хүүхэд хамгааллын чиглэлээр Орон нутгийн төсвөөс санхүүжилт олгогдоогүй ч улсын төсвийн санхүүжилтийг төлөвлөсөн арга хэмжээнд бүрэн зарцуулсан байна...16	16
2.1.1. Хүүхэд хамгаалалд зориулсан Улсын төсвөөс олгосон 2019-2021 оны санхүүжилтийг судалгаанд үндэслэн төлөвлөөгүй явж ирснийг 2022 оноос эхэлж арга хэмжээний нэр төрлөөр нь төлөвлөж байна.....	16
2.1.2 Хүүхэд хамгааллын төсвийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал нь ихэвчлэн хүүхдийн шинэ жилийн арга хэмжээ, сургалт хэлэлцүүлэг, уралдаан тэмцээнд зарцуулагдсан бөгөөд хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөл буурахгүй байна.	17
2.1.3 Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай нөөцийг судлан, судалгаа, баримтад үндэслэн оновчтой тодорхойлж, зардлыг хуваарилаагүй байна	17
2.2. Хүүхэд хамгаалалд төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл үр дүнгээ өгсөн боловч дотоод хяналт хангалтгүй, иргэд, олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.	18
2.2.1 Хүүхэд хамгааллын чиглэлээр олгосон санхүүжилт, хөрөнгийг зарим зүйлд зориулалт бусаар зарцуулсан байна.	18



2.2.2 Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтаа Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллээ байршуулсан, бусад мэдээллийн сувгаар иргэд, олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.....	19
2.2.3 Хүүхэд хамгааллын талаар Олон улсын донор байгууллагын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт дээд газар дээрээ хийгддэг тул үзэх боломжгүй байна.	19
2.2.4 Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг Нэг цэгийн үйлчилгээний төвийн байрны нөхцөл байдал хангалтгүй, ажиллах хүчин дутагдалтай байна.	19
2.2.5 Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн хувь хүний нууц бүрэн хамгаалагдаагүй байна.	20
2.2.6 Хүүхэд хамгааллын зардлыг 2019-2021 онуудад үйлчилгээний төрлөөр төлөвлөдөггүй байсан бол 2022-2023 онуудад зардлын ангиллаар нь төлөвлөж зарцуулсан байна.....	21
БҮЛЭГ-3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГАЧЛАЛ БАЙХГҮЙ Ч СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙГДСЭН БАЙНА.....	22
3.1. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжиж буй үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо бүрдээгүй байна.	22
3.1.1 Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх салбарын онцлогт нийцсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлал байхгүй байна.....	22
3.1.2 Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн талаар судалгаа шинжилгээ, нөхцөл байдлын үнэлгээ хийгдэж байна.	22
3.1.3 Хүүхэд хамгааллын чиглэлээр Олон Улсын байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмжөөс зарим асуудлын биелэлтийг хэрэгжүүлж ажиллаж байна.	23
3.1.4 Хүүхэд хамгааллын чиглэлээр Олон улсын байгууллага, төрийн бус байгууллагаас хэрэгжүүлсэн, үйл ажиллагаа хөтөлбөрийн үр дүнг тооцсон тухай баримт материал байхгүй байна.....	23
3.1.5 “Хүүхэд хамгааллын бодлого”-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдээгүй байна.....	23
3.1.6 Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал байхгүй байна.....	24
3.1.7 Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, зарим эерэг үр нөлөө бий болсон байна.	24
3.2. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ нь үр нөлөөгөө өгч эхэлж байна.	25
3.2.1 Гэр бүлийн орчинд чиглэсэн урьдчилсан сэргийлэх арга хэмжээ хүртээмж муутай байгаагаас шалтгаалан гэр бүлийн орчин дахь хүүхдийн хүчирхийллийн тоон үзүүлэлт буурахгүй байна.	25
3.2.2 Боловсролын салбар эрсдэлийг тодорхойлох тал дээр ахицтай сайн жишээ болохуйц ажил хийгдэн нийт суралцагчдын эрсдэлийг бүрэн үнэлж байгаа боловч хүүхэд хамгаалалтай холбоотой зөрчлийн шийдвэрлэлт, эрсдэлтэй хүүхдүүдтэй ажиллах, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх тал дээр дутмаг байна.....	28
3.2.3 Эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлж байгаа ч эмч нарыг хүүхэд хамгаалалтай холбоотой арга зүйгээр хангах, хуульд заасан тодорхой үүргийг таниулж ойлгуулах талаар мэдээллийг тогтмол хүргэх шаардлагатай байна.	34




3.2.4 Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны салбарт хүүхэд хамгааллын нэгдсэн бодлого байхгүй байна.....	36
3.2.5 Олон нийтийн арга хэмжээ, Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.....	37
3.2.6 Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгааллын талаар зохих арга хэмжээг авч ажиллажээ.....	37
3.3. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа үр дүнд ахиц гарч байна.....	39
3.3.1 Монгол Улс Хүүхдийн эрхийн олон улсын конвенцод нэгдсэн үүргийн талаар жил бүрийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.....	39
3.3.2 Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийгдээгүй, үр дүнгийн мөрөөр арга хэмжээ авч ажиллаагүй байна.....	40
3.3.3 Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээнүүдийг авч ирсэн байна.....	41
3.3.4. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн хэргийн суурь шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан байна.....	44
3.3.5 Зарим салбаруудын хувьд судалгаа, шинжилгээ хийгдээгүй; салбар хоорондын уялдаа хангалтгүйгээс эрсдэл буурахгүй байна.....	45
ДЭЭД ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ	47
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	48
ДҮГНЭЛТ	49
ЗӨВЛӨМЖ:.....	50



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БЗДХ	Бэлгийн замын дархлал хомсдол
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучууд хөгжлийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МГБССН	Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг
НАМС	Нийгмийн ажилтны мэдээллийн сан
НТБТ	Насан туршийн боловсролын төв
НҮБХАС	Нэгдсэн үндэсний байгууллагын хүн амын сан
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТХБ	Тогтвортой хөгжлийн боловсрол
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
ХНХС	Хөдөлмөр нийгэм хамгааллын сайд
ХТУ	Хүүхдийн тусламжийн утас
ХЭХЗХ	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭХЭМҮТ	Эх хүүхэд эрүүл мэндийн үндэсний төв



ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График-1	Сумдын нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн 2019-2023 оны ажил байдлын судалгаа
График-2	Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл 2019-2023 он

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт-1	Өвөрхангай аймагт хэрэгжсэн бодлого, хөтөлбөрийн уялдаа, зөрүүтэй байдал
Хүснэгт-2	Аймгийн ХГБХХГ-т ашиглагдаж байсан болон одоогоор ашиглагдаж буй системүүд
Хүснэгт-3	Аймгийн ХГБХХГ-ийн 2019-2023 оны хүний нөөцийн судалгаа
Хүснэгт-4	Аймгийн ХГБХХГ-ийн 2019-2023 оны төсөв
Хүснэгт-5	Аймгийн ХГБХХГ-ийн Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын санхүүжилт
Хүснэгт-6	Аймгийн ХГБХХГ-т улсын төсвөөс олгосон санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл 2019-2023 оны байдлаар
Хүснэгт-7	Аймгийн нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн тоо 2019-2023 оны байдлаар
Хүснэгт-8	Насанд хүрээгүй хүүхэд хохирсон бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо
Хүснэгт-9	Урьдчилан сэргийлэх, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн тоо
Хүснэгт-10	Өвөрхангай аймгийн хүн амын тоо болон 0-18 нас хүртэлх хүүхдийн тоо
Хүснэгт-11	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоо
Хүснэгт-12	Гэр бүлийн хэрэг, зөрчлийн мэдээлэл
Хүснэгт-13	Гэрлэлт ба гэр бүл цуцлалтын мэдээлэл 5 жилээр
Хүснэгт-14	“Багш айлчлал аргачлал”-р тодорхойлсон эрсдэлийн судалгаа
Хүснэгт-15	Өвөрхангай аймгийн ЕБС-уудын сэтгэл зүйчдийн судалгаа
Хүснэгт-16	Боловсролын салбар дахь 108 утасны дуудлага
Хүснэгт-17	Өсвөр насны хүүхдүүдийн өвчлөлтэй холбоотой зарим үзүүлэлтүүд
Хүснэгт-18	Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагын тоо /ОНАХ/
Хүснэгт-19	Аймгийн Онцгой байдлын газраас хийсэн ухуулга сурталчилгаа, сургалтад хамрагдсан хүүхдийн тоо
Хүснэгт-20	Аймгийн хэмжээнд 2019-2023 онд гал түймэр, аюулт үзэгдлийн улмаас нас барсан хүүхэд
Хүснэгт-21	Аймгийн хэмжээнд 108 утсанд ирсэн дуудлагын тоо
Хүснэгт-22	Аймгийн хэмжээний нийт хүүхдийн тоог эрсдэлт нөхцөлд орсон хүүхдийн тоонд харьцуулсан байдал
Хүснэгт-23	Аймгийн хэмжээний нийт дотуур байрны хүүхдийн болон багшийн тооны мэдээлэл
Хүснэгт-24	Аймгийн хэмжээний нийт хамтарсан багийн мэдээлэл



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаалын дагуу Төрийн аудитын тухай хуулиар олгогдсон эрхийн хүрээнд Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон бий болсон үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан Улсын Их Хурлын байнгын хороо, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго оршино.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

1. Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх;
2. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх;
3. Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Боловсролын газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Соёл, урлагийн газар, эдгээр байгууллагуудын харьяа 19 сумын байгууллага, мэргэжилтнүүд, бусад холбогдох байгууллагуудын 2019-2023 оны хүүхэд хамгааллын чиглэлээр хийсэн үйл ажиллагааны тайлан, мэдээлэлд тулгуурлан аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, судалгаа явуулах, ярилцлага хийх зэрэг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний арга зүйг ашиглан аудитыг хийж гүйцэтгэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.



**Аудитад
ашиглах хууль
тогтоомж,
шалгуур
үзүүлэлтүүд**

Дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

Үүнд:

- Хүүхдийн Эрхийн Тухай Конвенц;
- Монгол Улсын Үндсэн хууль;
- Хүүхэд хамгааллын тухай хууль;
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Боловсролын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр;
- Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл;
- НҮБ болон Олон Улсын байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмж

**Аудит хийх
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Д.Гансүх хэрэгжүүлж, гүйцэтгэл-нийцлийн аудитын багийн ахлах аудитор П.Хорлоосүрэн, аудитор Ө.Ринчинмядаг, П.Норпил нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Хүүхэд хамгааллын тухай хууль нь анх 2016 онд батлагдсанаас хойш 6 удаагийн нэмэлт өөрчлөлт орж, 50 орчим журам, 8 стандартыг мөрдөж ажиллаж байна. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2023 онд батлагдсан бөгөөд 2024 оны 9 дүгээр сарын 1-ээс эхлэн дагаж мөрдөхөөр тусгажээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгад “хүүхэд хамгаалал” гэж нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энэ хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг хэлнэ гэж заасан. Харин “хүүхэд хамгааллын үйлчилгээ” гэж хүүхэд хамгааллын тогтолцооны оролцогч талуудаас хүүхдийн хамгаалуулах эрхийг хангах зорилгоор үзүүлж байгаа шуурхай тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг хэлнэ” гэж тус заасан байна.

Хүүхэд хамгааллын талаар НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенц, Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл, Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т тус тус тусган хэрэгжүүлж байна.




Өвөрхангай аймагт 2023 оны байдлаар нийт 115757 хүн амын 37.7 хувь буюу 43668 нь хүүхэд байна.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд 2019-2023 онд нийт 448 дуудлага хүлээж авсан 2021 он өмнөх онтой харьцуулахад дуудлагын тоо хамгийн их 68 хувийн өсөлттэй 94 байсан байна.

Аймгийн хэмжээнд 2019-2023 онд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа, хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан нийт 2563 хүүхэд; хүүхдийн асрамж, халамжийн төвд асран хамгаалуулж байгаа 83 хүүхэд; түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлж, аюулгүй байдлын хамгаалалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан 196 хүүхэд бүртгэгдсэн ба 2020, 2022 онуудад тус 3 үзүүлэлт өөрчлөлт ихтэй байсан байна.

Өвөрхангай аймгийн хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний батлагдсан төсвийг доорх графикаар харуулав. 2022, 2023 онуудад санхүүжилт өссөн байна.



Хүндрэл бэрхшээл:

1. Орон нутгийн сонгуультай холбоотой холбогдох байгууллагуудаас баримт материал ирэхгүй удааширсан.
2. Аймаг, сумдын нийгмийн ажилтнууд олон удаа солигдсонтой холбоотой судалгаа, дүн шинжилгээ хийсэн баримт материал дутмаг байлаа.

Аудитаар 12.5 сая төгрөгийн 1 албан шаардлага, 19 зөвлөмж өгч, 12.5 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж хүлээн зөвшөөрүүлсэн.



САЛБАР БҮРД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНГЭЭ ӨГЧ ЭХЭЛСЭН БОЛОВЧ, ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГАЧЛАЛ БАЙХГҮЙ; ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ НЭГДСЭН БОДЛОГО, ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БИШ БАЙНА.

БҮЛЭГ-1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БИШ БАЙНА.

1.1. Хүүхэд хамгааллын бодлого, тогтолцоо нь нийгмийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцээгүй байна.

1.1.4 Хүүхэд хамгааллын талаар мөрдөж буй хууль тогтоомж, зарим бодлогын баримт бичиг хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2016 оноос эхлэн эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгох, шинэчлэх зэрэг ажлууд хангалттай хийгдсэн байна. Шинэчлэлийн хүрээнд хүүхэд хамгааллын ойлголт, нэр томьёо тодорхой болж, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг мэдээлэх, түүнийг хүлээн авч бүртгэх, тухайн тохиолдолд үзүүлэх хариу үйлчилгээг шуурхай үзүүлэх нөхцөл бүрдэж эхэлсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай зэрэг шинээр батлагдсан хуулиудын хэрэгжилтийг дэмжин, хуульд заасны дагуу гарсан олон журмыг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байна. Тухайлбал:

- Хууль батлагдмагц хэрэгжиж эхлэх хугацаа болон дагалдах журмуудын хэрэгжиж эхлэх хугацаа богино,
- Бодлогын баримт бичгийн төслийг шуурхай боловсруулах, хэрхэн хэрэглэх талаар арга зүйн сургалт явуулаагүй зэргээс ойлголтын зөрүү үүсэх,
- Хуулийг гол хэрэгжүүлэгч Хамтарсан баг, ХЭХЗХ-ны үйл ажиллагаанд тодорхой удирдамж, арга зүй өгөөгүй байх,
- Төсөв хөрөнгө дутагдах зэрэг асуудлууд байна.

Хүүхдэд хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хамгаалуулах, сурч боловсрох, хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрх, эрх чөлөөг нь хангахад чиглэсэн бодлогыг тасралтгүй хэрэгжүүлж, хөрөнгө, санхүүжилтийг нэмэгдүүлсээр байна.

Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй бодлого нь Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд анхаарч ажилласан байна.


Жишээлбэл: Алсын хараа 2030, 2050 зэрэг урт хугацааны хөгжлийн баримт бичгийг Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан боловсруулж, хэрэгжүүлж байгаа явдал юм.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойш Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор “Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг”, 2022 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/110 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар батлах тухай” зэрэг бодлогын баримт бичгүүд батлагдсан байна.

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг хуулийн хэрэгжилтийг хангах хуульчилсан актуудад нийцүүлэн баталсан аймгийн хөтөлбөрүүдийн онцлог харилцан уялдаа болон зөрүүг харуулбал:

Хүснэгт-1 Өвөрхангай аймагт хэрэгжсэн бодлого, хөтөлбөрийн уялдаа, зөрүүтэй байдал

Хөтөлбөрийн нэр	Хүүхдэд ээлтэй аймаг /2017-2020/	Адил боломж /2017-2021/	Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай /2017-2020/	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх /2021-2024/
Харилцан уялдаж үндэсний хөтөлбөр буй	“Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-т тусгагдсан эрүүл, аюулгүй орчинд	“Боловсрол” үндэсний хөтөлбөрт тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг	“Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-т тусгагдсан эрүүл,	“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-т нийцүүлсэн



	амьдрах, таатай орчныг бүрдүүлэх, орчны нөлөөллөөс шалтгаалах эрсдэл бүхий нөхцөл байдлыг илрүүлэх	хамгаалах, эрүүл хүүхдийн адил хөгжүүлэх, оролцуулах боломжоор хангах	аюулгүй орчинд амьдрах, таатай орчныг бүрдүүлэх, орчны нөлөөллөөс шалтгаалах эрсдэл бүхий нөхцөл байдлыг илрүүлэх	тусгасан гэр бүлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх зэрэг асуудлыг тусгах
Зөрүүтэй байдал	Нөхөн үржихүйн болон сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой эрүүл амьдралын хэв маягт төлөвшүүлэхтэй холбоотой	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчийн хариуцлагатай байдал, нийгмийн хандлагын зэрэг хандлагыг бий болгох	Хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа эрчимжүүлэх	Ядуурлын шугамын ерөнхий үзүүлэлт, ажилгүйдлийн түвшин нэмэгдэж буй статистик үзүүлэлт

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ

Хүүхдийн эрх, язгуур эрх ашиг, тэдний аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл, үл хайхрах байдал, осол гэмтэлд өртүүлж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад шаардагдах хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах шаардлага үүсэж байна.

Олон улсын эрх зүйн зохицуулалтын талаар

Олон улсын гэрээ, конвенцод нэгдэх, соёрхон батлах асуудлыг Улсын Их Хурал бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэдэг бөгөөд Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенц нь Монгол Улсын Олон улсын гэрээ болж үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчлэхийг Үндсэн хуульд заасан. Монгол Улс одоогийн байдлаар хүн, хүүхдийн эрхтэй холбоотой олон улсын 60 гаруй гэрээнд нэгдэн орж соёрхон баталсан байна.

1.1.6 Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй хөтөлбөрийн оролцогч талуудын үүрэг хариуцлага, оролцоо дутмаг байна.

Монгол улсын нийт хүн амын гуравны нэгийг эзэлж буй хүүхдэд зориулан хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийн хүлээн авагчдын гол онцлог нь тэдгээрийн нас, хүйс, эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалагдах эрхийг хангахад дан ганц төрийн бодлого хангалтгүй бөгөөд хүүхдийн хамгааллын асуудлыг голлон хэрэгжүүлэгч нь гэр бүл, асран хамгаалагч нар байна.

Хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд хүүхдийн эрх ашгийг хамгаалах, үндсэн хэрэгцээ шаардлагыг хангахад гэр бүл, асран хамгаалагчийн үүрэг оролцоо их байдаг нь аудитын явцад ажиглагдаж байна. Төрөөс үзүүлж буй мөнгөн тусламж, хэрэгжүүлж буй бодлого, боловсрол, эрүүл мэндийн салбарын үйлчилгээ нь хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжүүлэхэд зориулсан нэмэлтээр бий болгож буй хоёрдогч үйлчилгээ юм.

Цаашид хүүхдийн эрх ашгийг бүрэн ханган ажиллахын тулд хүүхдийн оролцоог бодитой болгох, хүүхдэд амьдрах ухаан, асуудлыг даван туулах чадавхыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, үйл ажиллагааг тэгш, хүртээмжтэй байдлаар зохион байгуулах шаардлагатай байна.

Иргэдийн дунд хүүхэд хамгаалал гэдгийг хүүхэд гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон хойно нь хүүхдэд үзүүлэх үйлчилгээ гэсэн ойлголт давамгайлж байгаа бөгөөд хүүхэд хамгааллын амин сүнс нь урьдчилан сэргийлэх ажил гэдгийг иргэд, үүрэг хүлээгчдийн зүгээс төдийлөн ухамсарлахгүй байна. Үүний нэг илрэл нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээж байгаа хүүхэд хамгааллын мэдээлэлд хүүхэд эрсдэлд орсон нөхцөлд Хүүхдийн тусламжийн утас 108-д мэдээлнэ, Хамтарсан баг үйлчилгээ үзүүлнэ гэсэн агуулгатай мэдээлэл, сурталчилгаа давамгайлж байгаагаас харж болно.



1.2. Аймгийн ХГБХХГ нь чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан боловч хүний нөөцийн хүртээмж хангалтгүй, мэдээллийн сан бүрэн үүсээгүй байна.

1.2.2 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан ч эрх нь зөрчигдсөн хүүхдийг дагнасан үйлчилгээгээр бүрэн хангаж ажилласан эсэхийг бүхэлд нь дүгнэн үзэх боломжгүй байна.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлд¹ Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын үүрэг, оролцоог заасан бөгөөд эдгээр заалтын хэрэгжилтийг дүгнэн үзэхэд:

Өвөрхангай аймгийн хэмжээнд “Хүүхэд хамгааллын бодлого 2015-2024” хэрэгжиж байгаа бөгөөд тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн дэд хөтөлбөр “Хүүхдэд ээлтэй аймаг 2017-2020”, Адил боломж 2017-2021, Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай 2017-2020, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 2021-2024 хөтөлбөрүүд батлан, хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ХГБХХГ-ийн хүүхдийн эрхийн улсын байцаагч 2019-2023 онуудад боловсролын байгууллагууд, шашны байгууллагууд, хүүхдийн асрамжийн төв зэрэг байгууллагуудад хяналт тавьж ажиллажээ.

Тус байгууллагад хүүхдийн тусламжийн 108 утас, хамтарсан багуудын илрүүлэлт, өргөдлөөр болон бусад холбогдох байгууллагуудын дуудлага мэдээллээр эрх нь зөрчигдсөн хүүхдүүдийн мэдээлэл ирдэг бөгөөд 2019-2023 оны байдлаар 108 утсанд 446 дуудлага ирж, бусад сувгаар орж ирсэн дуудлагын нэгдсэн бүртгэл байхгүй байна. Иймээс аудитын явцад 108 утсанд дуудлагын шийдвэрлэлтэд дүгнэлт хийх боломжтой байсан ба тус тусламжийн утасны дуудлага шийдвэрлэлтийг хамтарсан багуудтай хамтран гаргаж, эрх нь зөрчигдсөн хүүхдүүдийг шаардлагатай үйлчилгээгээр хангасан байна.

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хувьд гэр бүл рүү чиглэсэн үйл ажиллагааны хамрагдалт хангалтгүй байна. Харин Боловсрол, Эрүүл мэнд, Онцгой байдал, Цагдаагийн байгууллагын хувьд хамтран болон, дагнасан байдлаар сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг хангалттай сайн явуулсан байна.

Хүүхэд хамгааллын асуудлын шийдвэрлэлт дээр аймгийн хэмжээнд анхан шатанд ажиллаж буй 36 хамтарсан баг ажиллаж байгаа ба 2019-2023 оны байдлаар хамтарсан багуудын мэдээ тайлан бүрэн бус, аймгийн ХГБХХГ дээрх хамтарсан багуудын тайлангийн нэгтгэл хангалтгүй байна. Энэ нь аймаг, суманд боловсон хүчний тогтвортой байдал муу байсантай холбоотой байна.

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь хуульд заасан чиг үүргүүдээ тодорхой хэмжээнд хэрэгжүүлж ажилласан ч аудитын явцад үүссэн бичиг баримтын хязгаарлагдмал байдлаас үүдэлтэй эрх нь зөрчигдсөн хүүхдийг дагнасан үйлчилгээгээр бүрэн хангаж ажилласан эсэхийг бүхэлд дүгнэн үзэх боломжгүй байна.

¹15.1.1.тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх бодлого, төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

15.1.2.тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих;

15.1.3.эрх нь зөрчигдсөн хүүхдийг дагнасан үйлчилгээгээр хангаж, хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, асрамжийн зэрэг шаардлагатай үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;

15.1.4.хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн ажлыг гэр бүл, олон нийтийн оролцоо, дэмжлэгт тулгуурлан холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

15.1.5.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн тухайн шатны байгууллага, ажилтан нь хүүхэд, гэр бүл, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг зөвлөгөө, мэдээллээр хангах, шаардлагатай бол сургалт зохион байгуулах, нийгмийн ажилтны үйл ажиллагааг дэмжиж, арга зүйн удирдлагаар хангах;

15.1.6.энэ хуулийн 14.2-т заасан журмын дагуу анхан шатны байгууллага, ажилтан, хамтран ажиллаж байгаа хуулийн этгээдээс мэдээ тайлан авч, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаар зөвлөмж өгөх, хэрэгжилтийг хянах, холбогдох мэдээллийг нэгтгэн төв байгууллагад хүргүүлэх;

15.1.7.хүүхэд гишүүнчлэлтэй болон эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаа хэрэгжүүлэх хуулийн этгээдийн үйл ажиллагааг төрөөс дэмжин, байр, танхимаар хангах;

15.1.8.хүүхдийн эрхийн чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

15.1.9.хууль тогтоомжид заасан бусад.



1.2.5 Хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан дутмаг, үйл ажиллагаанд хэрэглэгдэж байсан системүүдийн ашиглалт хаагдсанаас шалтгаалан цахим мэдээллийн сан бүрэн үүсээгүй, зарим мэдээлэл архивлагдаагүй байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2019-2023 онд Хүүхэд хамгааллын статистик үзүүлэлтийг Монгол улсын Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны а/145 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-ын дагуу 129 үзүүлэлтээр, мөн 2022 оны А/172 дугаар “Хүүхдийн эрх, хамгааллын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал батлах тухай” тушаалаар 169 үзүүлэлт, Хүүхдийн төлөө Үндэсний газрын /хуучин нэрээр/ даргын 2016 оны а/28 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу хүүхэд хамгааллын статистик 13 бүлэг үзүүлэлтийг холбогдох маягтын дагуу статистик мэдээлэл гаргасан. Хүүхэд хөгжил хамгааллын мэдээг улирлаар, гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн мэдээллийг улирлаар, нэг цэгийн үйлчилгээний төвийн мэдээллийг сараар тус тус 19 сум бусад холбогдох байгууллагаас мэдээллүүдийг авч нэгтгэж байна.

Үндэсний Статистикийн хорооны 2015 оны Хүүхэд хамгааллын 129 үзүүлэлт тооцох аргачлалын дагуу аймгийн Цагдаагийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар зэрэг нийгмийн 7 салбар, сумдын Нийгмийн бодлогын мэргэжилтнүүд, багийн нийгмийн ажилтнаар дамжуулан анхан шатны нэгжээс статистик тоон судалгааг нэгтгэн, мэдээллийн санг өргөжүүлж, “Статистик-2021”, “Статистик-2022” эмхэтгэлийг боловсруулан гаргасан байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1²-д хамтарсан баг тайланг хагас, бүтэн жилээр нэгтгүүлэхээр заасан байдаг.

Гэвч 19 сумын хамтарсан багуудын хувьд журмын дагуу тогтмол мэдээ тайлангаа бүрэн ирүүлээгүй, аймгийн ХГБХХГ авч нэгтгэн тайлагнаагүй тул хамтарсан багуудын мэдээ тайлангууд дутуу, аудитын явцад баримттай ажиллахад хүндрэлтэй байлаа. Сумдад ажиллах явцад зарим сумдын нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд эрсдэлийн судалгаа байхгүй, хүүхдүүдийн эрсдэлийг үнэлэх нь зөвхөн боловсролын байгууллагын үүрэг мэт сургууль “Багш айлчлал” хөтөлбөрөөр эрсдэлийг тодорхойлно гэх тайлбар өгсөн.

Аймгийн ХГБХХГ болон сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүдийн хүний нөөцийн тогтворгүй байдал, сумдын хамтарсан багийн гишүүдийн оролцоо бага, салбар хоорондын мэдээлэл солилцоо хангалтгүй байгаагаас үүдэлтэй нэгдсэн тайлан, мэдээлэл бүрэн гаргаагүй, зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Цахимаар үүсэж буй мэдээллийн сангийн хувьд тус байгууллагад ашиглагдаж байсан болон одоогоор ашиглагдаж буй дараах системүүд байна. Үүнд:

Хүснэгт-2 Аймгийн ХГБХХГ-т ашиглагдаж байсан болон одоогоор ашиглагдаж буй системүүд

№	Программын нэр	Программд нэгтгэгддэг мэдээллүүд	Ашиглалтад орсон огноо	Ашиглалтаас гарсан огноо	Ашиглалтаас гарсан шалтгаан, түүний үр дагавар
1	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх хамгааллын	Нэг цэгийн үйлчилгээний төвд байрласан хүчирхийллийн хохирогч хүүхэд	2019	2023 оноос эхлэн аймгийн Цагдаагийн газрын гэр бүлийн асуудал	Программын хөгжүүлэлт муугаас болж ашиглахад маш хэцүү, гацах, алдаа

² 3.1.1. Хамтарсан баг ажлаа хагас, бүтэн жилээр төлөвлөн хэрэгжүүлж, тайлангаа аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, орон нутгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

	үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан /ТХБ, НЦҮТ/ www.etuslamj.mn	эмэгтэйчүүдийн талаарх кейсийн материал		хариуцсан мэргэжилтэн нэвтрэн орж байгаа.	заах асуудлууд байнга гардаг.
2	ХТУ 108 Программ www.child.gov.mn	Нийгмийн бүх орчинд хүүхдийн эрх ашиг зөрчигдсөн талаарх дуудлага мэдээллийг хүлээн авах ба дуудлагын дагуу ажилласан бүх материалыг нэгтгэн оруулдаг тусламжийн утасны программ.	2015	Одоо ашиглаж байгаа.	-
3	Нийгмийн ажилтны мэдээллийн сан /НАМС/ www.nas.gov.mn	Эрсдэлт нөхцөл дэх хүүхэд болон тэдний гэр бүлийн талаарх мэдээлэл, хаагдсан болон ажиллаж байгаа бүх кейсийн материал	2022	2023	ХГБХХЕГ-тай хийсэн программ ашиглалтын гэрээ сунгагдаагүй.
4	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын мэдээллийн сан www.intranet.gov.mn	Хурдан морь унаач хүүхдийн мэдээлэл, асрамж халамжийн төвүүдэд байрлаж байгаа хүүхдүүдийн мэдээлэл	2019	Одоо ашиглаж байгаа.	-
5	"Able" удирдлагын нэгдсэн систем	Асрамж, халамжийн үйлчилгээ, хурдан морины уралдаан, хүүхдийн зуслангийн бүртгэлүүд, эрсдэлийн үнэлгээний бүртгэл	2019	2021 оноос эрсдэлийн үнэлгээний бүртгэл хийгдэхээ больсон.	Тус программын эрсдэлийн үнэлгээ хийх асуулгууд сайдын 2017 оны тушаалаар батлагдсан "Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам"-с өөр асуулгатай байсан тул мэдээллийн зөрүүтэй байдал үүссэн.

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын мэдээлэл

Нэг цэгийн үйлчилгээний бүртгэл мэдээллийн программ WWW.ETUSLAMJ.MN; нийгмийн ажилтнуудын судалгаа, бүртгэл мэдээллийг цахимжуулалтын WWW.NAS.GOV.MN системүүд одоогоор ашиглагдахгүй, ашиглаж байх үед хадгалагдсан мэдээллүүдийг эргэн ашиглах, харах боломжгүй болсон байна.

"Эйбл" удирдлагын нэгдсэн системийн эрсдэлийн үнэлгээний программд 2019, 2020 онуудад бүртгэл хийсэн боловч асуулгын зөрүүтэй байдлаас шалтгаалан 2021 оноос ашиглалтгүй болсон байна. Аймгийн хэмжээнд эрсдэлийн үнэлгээний мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй байна.

Дүгнэн үзэхэд:

- Цаасан, болон цахим мэдээллийн сангууд бүрэн үсээгүй.
- Мэдээллийн бодит байдал дутмаг.
- Мэдээллийн сангийн баяжилт хангалтгүй байна.
- Салбар хоорондын мэдээлэл солилцоо хангалтгүй байна.

Цаашид Цагдаа, Эрүүл мэнд, Боловсролын байгууллага, бусад холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ, программ ашиглаж мэдээллийн уялдааг хангаж ажиллах шаардлага үүсэж байна.



1.2.6 Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад аймгийн ХГБХХГ, сумдад хүний нөөц тогтворгүй, зарим тохиолдолд зайлшгүй нөхцөл байдлаас үүдэлтэй мэргэжлийн бус хүн ажиллуулж байна.

Өвөрхангай аймгийн Засаг даргын 3 удаагийн захирамж, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын 1 удаагийн тушаалаар 2019-2023 онд дараах байдлаар орон тоог батлан, ажилласан байна. Үүнд:

Хүснэгт-3 Аймгийн ХГБХХГ-ийн 2019-2023 оны хүний нөөцийн судалгаа

№	Он	Хүний нөөцийн мэдээлэл					Ажилласан дундаж жил /Нийт ажилласан жил/				Тухайн жилд томилогдсон, чөлөөлөгдсөн тухай мэдээлэл	
		Батлагдсан орон тоо	Ажиллаж байгаа орон тоо	Үүнээс Нийгмийн ажилтан	Сэтгэл зүйч	Бусад	1 жил хүртэл	2-3 жил	4-5 жил	5-аас дээш жил	Шинээр томилогдсон	Чөлөөлөгдсөн
1	2019	26	26	1	1	24	6	3	7	10	5	4
2	2020	28	28	1	1	26	3	9	8	8	3	3
3	2021	28	28	2	1	25	4	8	9	7	4	4
4	2022	27	27	2	1	24	8	4	8	7	6	7
5	2023	27	27	1	1	25	7	5	8	7	8	10

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын судалгаа

Дээрх судалгаанаас харахад 2019-2023 онуудад 4 удаагийн шийдвэрээр орон тоо, бүтэц, ажлын байрны нэршилд өөрчлөлт их орж удирдлага, мэргэжилтнүүд болон үйлчилгээний албан хаагчид чөлөөлөгдсөн, томилогдсон хөдөлгөөн их гарсан байна.

Батлагдсан орон тоонд 2020 онд өөрчлөлт орж захиргаа, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн; мэдээллийн сан, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн гэсэн 2 орон тоо нэмэгдсэн байна. Харин 2021 оны орон тооны бүтцээр хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоо хасагдан /ахлах мэргэжилтэнтэй хавсран гүйцэтгэхээр/, нэг цэгийн үйлчилгээний төв хариуцсан нийгмийн ажилтны орон тоо нэмэгдсэн байна.

Орон тооны бүтцэд 2022 онд өөрчлөлт орж хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоог хавсран бус үндсэн орон тоо болгон нэмэгдүүлж, НЦҮТ-ийн 3 жижүүрийг гэрээт ажилтнаар томилон ажиллуулсан байна.

Аймгийн ХГБХХГ-т 2019-2023 онд хуулийн дагуу батлагдсан ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжлийн албан хаагчид ажилласан байна.³


Аймгийн 19 сумдын нийгмийн бодлогын асуудал хариуцсан ажилтнуудын хувьд 2019-2023 онуудад нэг суманд 2-6 удаа солигдон түр, хавсран, үндсэн орон тоогоор ажилласан байна. Солигдсон байдлыг сумдаар харуулбал:

График-1 Сумдын нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн 2019-2023 оны ажил байдлын судалгаа


³ Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв, хэлтэс, газарт болон сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн хөгжлийн ажилтан нь хүмүүнлэгийн болон нийгмийн ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байна."



Сумдын нийгмийн бодлогын асуудал хариуцсан
мэргэжилтнүүдийн судалгаа / солигдон ажилласан
хүний тоо 2019-2023 он/



Сумдын нийгмийн бодлогын мэргэжилтэнүүдийн
ажилласан байдал /2019-2023 оны нийт дүнгээр



Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын судалгаа

Сумдын мэргэжилтнүүдийн 2019-2023 онд ажилласан байдлыг мэргэжлээр нь авч үзвэл:

- Аялал жуулчлал менежментийн удирдлага-1
- Зоо техникч-1
- Зураглаач-1
- Кино видео техникч-1
- Номын санч-1
- Нярав-1
- Хүний нөөцийн мэргэжилтэн-1
- Хүнс үйлдвэрлэлийн технологич-1
- Шувуу судлаач-1
- Эдийн засагч-1
- Сэтгэл зүйч-2
- Философи, улс төр судлаач-2
- Нягтлан бодогч-3
- Нийгмийн ажилтан-5
- Төрийн захиргаа удирдлага-8
- Эрх зүйч-12
- Мэдээлэл зүй-Англи хэл, Физик, Монгол хэл-Уран зохиол, Түүх-Нийгэм, Биеийн тамирын багш-25


Сумдын нийгмийн бодлогын асуудал хариуцсан албан хаагчид тогтвор суурьшилгүй ажилласнаас хүүхэд, хөгжил хамгааллын ажлыг тасалдуулахгүйн тулд мэргэжлийн бус хүмүүсээр албан үүргийг гүйцэтгүүлж ирсэн байна. Тухайлбал: Баянгол, Санта, Хайрхандулаан, Өлзийт, Гучин-ус, Зүүнбаян-Улаан гэх мэт ихэнх сумууд 2021 оноос хойш нийгмийн бодлогын мэргэжилтний ажлыг хавсран гүйцэтгэсэн байна.

Орон нутгийн төрийн байгууллагад ажилладаг нийгмийн ажилтнуудын тогтвор суурьшилгүй ажиллах гол шалтгаанууд нь:

- Давхар олон чиглэлийн өргөн хүрээтэй үүрэг хүлээдэг тул ажлын ачаалал их,
- Нийгмийн баталгаа тааруу /цалин хөлс бага/
- Олон төрлийн эрсдэлт нөхцөлийн дуудлагуудын дагуу хүнд нөхцөлд /хохирогч, хэрэгт холбогдогчидтой/ ажилладаг

Аймгийн ХГБХХГ-аас авсан хүний нөөцтэй холбоотой санал асуулгаас харахад:

1. Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хүний нөөцийн орон тоо хүрэлцээтэй байдаг эсэх? /ямар орон тоо дутагдалтай байна вэ/	2. Хүний нөөцтэй холбоотой нэмэлт санал.	3. Бүтэц орон тоо, албан тушаалын нэршил ихээр өөрчлөгдсөн байна. Үүний шалтгаан юу вэ?
Орон тоо дутмаг. Хүн ам, хүүхдийн тоог харгалзан Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоог нэмэх. Сумдад зөвхөн хүүхэд хамгааллын асуудал хариуцсан ажилтантай болох.	Нийгмийн хамгааллын салбарт хүний нөөцийг тогтвортой байлгах гол үндэс нь албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүнтэй ажиллах сэтгэлтэй, зөв хандлагатай хүмүүсийг бэлтгэх, сонгон ажиллуулах	Яам, ерөнхий газрын удирдлагын тогтворгүй байдал, хууль, дүрэм журмын шинэчлэлтэй холбоотой.



Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд анхан шатнаас эхлэн шат шатны үйл ажиллагаанд чухал үүрэгтэй оролцож хүүхэд хамгааллын баг, сумдын нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн, аймгийн ХГБХХГ-ын албан хаагчдын хувьд тогтвор суурьшил муутай байна. Энэ нь хүүхэд хамгааллын үйл ажиллагааны чанарт сөргөөр нөлөөлж байна.

БҮЛЭГ-2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫГ 2019-2021 ОНУУДАД ТООЦОО СУДАЛГААНД ҮНДЭСЛЭЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ ДЭЭД ГАЗРААС ШУУД САНХҮҮЖИЛТ ОЛГОЖ ИРСЭН БОЛ 2022 ОНООС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭР ТӨРӨЛ, АРГА ХЭМЖЭЭГЭЭР НЬ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

2.1. Хүүхэд хамгааллын чиглэлээр Орон нутгийн төсвөөс санхүүжилт олгогдоогүй ч улсын төсвийн санхүүжилтийг төлөвлөсөн арга хэмжээнд бүрэн зарцуулсан байна.

2.1.1. Хүүхэд хамгаалалд зориулсан Улсын төсвөөс олгосон 2019-2021 оны санхүүжилтийг судалгаанд үндэслэн төлөвлөөгүй явж ирснийг 2022 оноос эхэлж арга хэмжээний нэр төрлөөр нь төлөвлөж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 12-ны А/13 дугаар тушаалыг үндэслэн хүүхэд хамгааллын зардлыг 2019-2022 онуудад ангилал тус бүрээр төлөвлөөгүй, шууд дээрээс төсөв хуваарилсан байна. Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/23, 27 тоот хамтарсан тушаалаар Аргачлал, зардлын нормативыг баталж өгсөн байна.

Монгол Улсын ХНХС-ын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01/450 тоот албан бичгээр тус журмын хэрэгжилтийг ханган ажиллаж 2023 оноос хойш төсвийн төсөл авч зардлын ангиллаар төлөвлөж ирсэн байна.

Хүүхэд хамгааллын зардлыг 3 төрлийн үйл ажиллагааны нэр төрлөөр арга хэмжээгээр нь ангилан төлөвлөсөн байна. Үүнд:

- Шуурхай тусламж /Эрсдэлт нөхцөлд байгаа буюу эрх нь зөрчигдсөн, гэмт хэрэг зөрчилд холбогдсон хүүхдэд эрүүл мэнд, хууль эрх зүй, сэтгэл зүй, боловсрол, нийгмийн халамжийн болон нэг цэгийн үйлчилгээний төвд бусад шаардлагатай үйлчилгээ үзүүлэх/
- Хамгаалах нөхөн сэргээх /Хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх шаардлагатай хүүхэд, гэр бүлд нийгэм сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх, эргэн хяналт хийх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ/
- Урьдчилан сэргийлэх /Нийгмийн бүх орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, хөгжүүлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага ААН-тэй хамтран хэрэгжүүлэх/

Аймгийн хэмжээнд санхүүжилтийн орлого бүрдүүлэлтийг графикаар харуулбал:

Хүснэгт-4 Аймгийн ХГБХХГ-ийн 2019-2023 оны төсөв

№	Он	Улсын төсөв	Орон нутгийн төсөв
1	2019	92,900,000	10,000,000
2	2020	228,890,686	10,000,000
3	2021	81,545,900	10,000,000
4	2022	200,594,812	20,000,000
5	2023	237,060,100	20,000,000
Нийт дүн		840,991,498	70,000,000

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын санхүүгийн мэдээлэл

Дээрх графикаас харахад хүүхэд хамгааллын зардал зөвхөн Улсын төсвөөс бүрдсэн байна. Гэхдээ орон нутгийн төсвөөс хүүхэд хамгаалах байрны 2 жижүүрийн цалингийн санхүүжилтийг олгосон байна.



2.1.2 Хүүхэд хамгааллын төсвийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал нь ихэвчлэн хүүхдийн шинэ жилийн арга хэмжээ, сургалт хэлэлцүүлэг, уралдаан тэмцээнд зарцуулагдсан бөгөөд хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөл буурахгүй байна.

Хүүхэд хамгааллын зардлыг санхүүжүүлэхдээ нарийн төлөвлөн, зарцуулалтын зориулалт, ангиллыг нарийвчлан зохицуулсан эрхзүйн баримт бичиг гаргах шаардлагатай байна.

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал нь 2019-2020 онуудад тусдаа ангиллаар орж ирдэггүй байсан бол 2021-2023 онд зардлын ангиллаар санхүүжилт нь орж ирсэн байна. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын санхүүжилтийг 5 жилээр харуулбал:

Хүснэгт-5 Аймгийн ХГБХХГ-ийн Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын санхүүжилт

№	Зардлын нэр	2019	2020	2021	2022	2023	Нийт дүн
1	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын санхүүжилт	46,000,000	98,371,700	38,062,019	60,020,000	50,621,000	293,074,719

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын санхүүгийн мэдээлэл

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийг доорх зардлуудад ихэвчлэн зарцуулагдсан байна. Тухайлбал:

2021 он	2022 он	2023 он
- Хүүхдийн шинэ жилийн арга хэмжээнд 7,080.0 мянган төгрөг - Сургалт хэлэлцүүлгийн зардалд 27,462.4 мянган төгрөг	- Хүүхдийн шинэ жилийн арга хэмжээнд 3,653.0 мянган төгрөг - Сургалт хэлэлцүүлгийн зардалд 39,602.5 мянган төгрөг - Уралдаан тэмцээний зардалд 16,732.9 мянган төгрөг	- Хүүхдийн шинэ жилийн арга хэмжээнд 10,367.5 мянган төгрөг - Сургалт хэлэлцүүлгийн зардалд 34,483.6 мянган төгрөг - Уралдаан тэмцээний зардалд 5,770.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Дээрх арга хэмжээнүүдэд хөрөнгө зарцуулсан боловч хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөл буураагүй байна. Тухайлбал: Цагдаагийн газарт гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 2020 онд **209**, 2021 онд **192**, 2022 онд **304**, 2023 онд **259** бүртгэгдсэн байна.

Хүүхдийн төлөө зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоол, хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь заалтын дагуу "Эцэг, эхийн зөвлөл"-ийн үйл ажиллагаа тогтмолжиж 2021 онд 121 эцэг эхийн зөвлөл ажиллаж байсан бол 2024 онд 162 байгууллага, аж ахуй нэгжийн дэргэд "Эцэг, эхийн зөвлөл" ажиллаж 33 хувиар өссөн, Хүүхэд хамгааллын бодлого батлан хэрэгжүүлж байгаа байгууллага 2021 онд 83, 2024 онд 104 байгууллага болж 25 хувиар өссөн байна.


2.1.3 Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай нөөцийг судлан, судалгаа, баримтад үндэслэн оновчтой тодорхойлж, зардлыг хуваарилаагүй байна.

Өвөрхангай аймагт хүүхэд хамгааллын зардлыг Улсын төсвөөс санхүүжүүлдэг бөгөөд бусад эх үүсвэрээс санхүүжилт олгогдоогүй байна.⁴

Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг 5 жилээр харуулбал:

Хүснэгт-6 Аймгийн ХГБХХГ-т улсын төсвөөс олгосон санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл 2019-2023 оны байдлаар

⁴ 38.1.2.хүүхэд хамгааллын санхүүжилт, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардлыг орон нутгийн төсөвт жил бүр тусгаж батлах;



ОН	Нөхцөл байдлын үнэлгээ хийх зардал /80236/		Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардал /80237/		Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал /80238/	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2019	-	24,870,000	92,900,000	22,030,000	-	46,000,000
2020	-	59,824,308	228,890,686	70,694,678	-	98,371,700
2021	-	20,181,900	81,545,900	23,301,981	-	38,062,019
2022	28,152,200	28,144,912	112,429,900	112,429,900	60,020,000	60,020,000
2023	19,706,900	19,706,900	166,732,200	166,732,200	50,621,000	50,621,000

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын санхүүгийн мэдээлэл

Сүүлийн жилүүдийн төсвийн зарцуулалтыг авч үзэхэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд зарцуулж буй зардал эрс нэмэгдэж байна. Энэ нь хүүхдийн хүчирхийлэл нэмэгдэж байгаа болон үйлчилгээний эрэлт хэрэгцээ өсөж байгаатай холбоотой юм. Мөн хүүхэд хамгаалалд урьдчилсан арга хэмжээ болон санхүүжилтийн төлөвлөлт тэр бүр оновчтой байж чадахгүй байгааг харуулж байна. Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад орон нутгийн төсвөөс санхүүжилт олгогдоогүй байна.

Харин 2024 оноос ЕБС-уудад хүүхэд хамгааллын зардал хүүхдийн тооноос хамааран төсөвт тусган баталж, зарцуулсан байна.

Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн тоог 5 жилээр харуулбал:

Хүснэгт-7 Аймгийн нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн тоо 2019-2023 оны байдлаар

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
108 дуудлагын тоо	54	57	75	115	78
Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн тоо	23	47	46	45	32

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээлэл

Дээрх судалгаанаас харахад хүүхдийн 108 дуудлагын тоо, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн тоо жил бүр нэмэгдсэн байхад зардал, санхүүжилт нь уялдаж нэмэгдээгүй байна.

Олгосон санхүүжилт ямар үр дүнд хүрсэн талаарх тайлан буюу үр дүнд суурилсан тайлан, санхүүжилтийн бодлого байхгүй байна.

2.2. Хүүхэд хамгаалалд төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл үр дүнгээ өгсөн боловч дотоод хяналт хангалтгүй, иргэд, олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.


2.2.1 Хүүхэд хамгааллын чиглэлээр олгосон санхүүжилт, хөрөнгийг зарим зүйлд зориулалт бусаар зарцуулсан байна.

Хөрөнгийг зарцуулах зориулалт, санхүүжүүлэх үүрэг, чиглэл нь холбогдох хууль, журамд нарийн тусгагдаагүй байна. Тиймээс хүүхэд хамгааллын зардал нь халамжийн үйлчилгээ болон бусад салбарын зардалтай давхцах, зориулалтын бусаар ашиглах зэрэг хүндрэлүүдтэй тулгардаг.

Зориулалт бусаар нийт 12,541.0 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнд:

- Сумдын мэргэжилтнүүдэд бэлэг өгсөн 901.0 мянга /2019 он/
- Аудит төлбөрт 440.0 мянган төгрөг /2019 он/
- Албан хаагчдын дэмжлэгт 11200.0 мянган төгрөг /2020 он/

Цаашид хүүхэд хамгааллын чиглэлээр ирсэн санхүүжилтийг зарцуулах зориулалт, ангиллыг нарийвчлан зохицуулсан эрхзүйн баримт бичиг гаргах шаардлагатай байна.



2.2.2 Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтаа Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллээ байршуулсан, бусад мэдээллийн сувгаар иргэд, олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.

Хүүхэд хамгааллын зардлын төсвийн мэдээлэл, зарцуулалт, санхүүжилтийн үр дүнгийн талаарх мэдээлэл ил тод биш байна. Тухайлбал: Байгууллагын сайтад төсөвтэй холбоотой гарсан шийдвэрүүдийг байршуулаагүй тул иргэд, олон нийт мэдээлэл авах боломжгүй байна.

Харин Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллүүдийг байршуулсан боловч шилэн дансанд хүүхэд хамгаалалд зориулж бусдаас өгсөн хандив, тусламжийн зарцуулалт ерөнхий байдлаар орсон нь зарцуулалтын ил тод байдал хангалтгүй байгааг илтгэнэ. Төсвийн зарцуулалт, зориулалт, ангилал тодорхойгүй байна.

2.2.3 Хүүхэд хамгааллын талаар Олон улсын донор байгууллагын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт дээд газар дээрээ хийгддэг тул үзэх боломжгүй байна.

Манай аймгийн хувьд Дэлхийн Зөн Монгол ОУБ, Японы Хүүхдийг Ивээх Сангийн хөтөлбөрүүд хэрэгжиж ирсэн байна. Тухайн ОУБ-ын материалууд төвдөө байдаг тул энд үзэх боломжгүй байна.

Тайлангаас товч дурдахад: Хүүхдийг ивээх сангаас 2.7 сая ам долларын санхүүжилттэй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төсөл нь 2019 оноос 2023 он хүртэл 4 жилийн хугацаатай хэрэгжиж эхлээд байна. Төслийн зорилго нь өсвөр үеийн хүүхэд, залуучуудад хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох замаар сурлагын амжилтыг сайжруулж, цаашлаад хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх юм. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Богд, Гучин-ус, Хархорин, Хужирт, Сант, Уянга Арвайхээр гэсэн 8 сумдын зорилтот 12 сургууль, зорилтот 7 НТБН-үүд дээр амжилттай хэрэгжиж 2020 оноос хойш нийт 1537 хүүхэд, залуучууд чадавхжиж төслийн үр шимийг хүртээд байгаа юм байна.


Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс хамгаалах, аюулгүй байдлаа хангах чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь төсөл хэрэгжсэн байна. Энэхүү төсөлд Арвайхээр ЕБ-ын 1 сургууль, аймгийн НТБТ, Эцэг эхийн холбоо гэсэн үндсэн 3 зорилтот бүлгийн хүрээнд хэрэгжсэн юм. 2023 оны 01 дүгээр сараас 6 сар хүртэл амжилттай хэрэгжсэн байна. Төслийн хүрээнд нийт 4990 ам долларын санхүүжилтийг орон нутагтаа татсан байна. Төслийн хүрээнд Аймгийн НТБТ, Эцэг эхийн холбоо, Салбар комисс болон Арвайхээр ЕБ-ын 1 сургуулийн нийт 5 сургагч багш амжилттай бэлтгэгдэн, 100 гаруй багш, эцэг эхчүүд, 50 гаруй сурагчдад сургалт мэдээлэл хүргэсэн байна.

2.2.4 Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг Нэг цэгийн үйлчилгээний төвийн байрны нөхцөл байдал хангалтгүй, ажиллах хүчин дутагдалтай байна.

Өвөрхангай аймгийн Хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийг түр хамгаалах байрыг 2019 онд шинэчилж аймгийн ОНХС-аас 80.0 сая төгрөг, НҮБ-ийн Хүн амын сангийн Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төслөөс 40.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Нэг цэгийн үйлчилгээний төв” болон өргөжүүлэн аймгийн Цагдаагийн газрын дэргэд 2020 онд шинээр барилгатай болсон байна.

Нэг цэгийн үйлчилгээний төвд байрлаж байгаа даван туулагчдыг чадавхжуулах, тэднийг хөдөлмөрт сургах, эрүүл хоол хүнсээр хангах зорилгоор хүлэмж барих төсөл бичиж, шалгаран НҮБ-ын Хүн амын хөгжлийн сангийн 55.0 сая төгрөгийн санхүүжилтээр 6:10 харьцаатай, 3 улирлын хүлэмжийг 2023 онд шинээр барьж ашиглалтад оруулсан.

Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS6040:2019 стандартын 11 дүгээр хэсгийн 11.1-д “Түр хамгаалах байранд мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч болон тогооч орон тоогоор ажиллана” гэж заасан боловч



аймгийн түр хамгаалах байранд одоогоор ХГБХХГ-ын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч ээлжээр ажилладаг бөгөөд орон тооны ажилтан байхгүй байна. Тус стандартын 11 дүгээр хэсгийн 11.3-т дагуу “Түр хамгаалах байрны хүчин чадал, санхүүжилтээс шалтгаалан хүүхэд хамгааллын ажилтан, халамжийн ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, жолооч, харуул хамгаалалтын ажилтныг гэрээгээр ажиллуулж болно” гэж заасны дагуу 2 нийгмийн ажилтан, 1 сэтгэл зүйч гэрээгээр 3 ээлжийн жижүүр үүрэг гүйцэтгэж байна.

Тус байр нь одоогоор стандартын шаардлага хангахгүй байна. Тухайлбал: Уг барилга нь даацын бус, хананд ан цав үүссэн, угаалгын өрөө шаардлага хангахгүй, нэг хүнд ногдох талбайн хэмжээ стандартдаа хүрэхгүй, галын аюулгүй байдал хангагдаагүй байна.

Нэг цэгийн үйлчилгээний төвийн зардлыг орон нутгийн төсвөөс гаргахаар хуульд заасан боловч орон нутгийн төсвөөс зардал баталж өгөөгүй байна⁵.

Харин аймаг, орон нутгийн төсвөөс 2019-2021 онд 10.0 сая төгрөг, 2022-2023 онд 20.0 төгрөгийн санхүүжилт өгч хүүхэд хамгаалах байрны гэрээтийн цалинд олгосон байна. ХГБХХГ-ын Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нь НЦҮТ-д өдрийн ээлжид (8 цаг) гарахаас гадна гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 108 утасны дуудлага мэдээлэл, хамтарсан багт кейс арга зүй өгөх, ирсэн өргөдөл гомдлын дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийх, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулах гэх мэт үндсэн үүрэгт ажлыг хийдэг учир мэргэжилтнүүдийн ажлын ачаалал их байдаг. Ажлын ачаалал, хүний нөөцийн дутмаг байдлаас болж байрлаж буй хүүхэд, эмэгтэйчүүдэд сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах, хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх, эргэх холбоотой ажиллах зэрэг ажлууд хоцрогдож байна.

Мөн байрлаж буй хүүхэд, эмэгтэйчүүдийг шүүх эмнэлэгт үзүүлэх, эмнэлгийн үйлчилгээнд холбон зуучлах хууль ёсны төлөөлөгчтэй мэдүүлэг өгөх зэрэг ажил гарахад заавал харгалзах хүнтэй явдаг тул өдрийн цагаар үйлчилгээг бүрэн үзүүлэхэд 2-оос дээш ажилтны шаардлага гардаг.

Аймаг, орон нутгийн хүүхэд хамгааллын байранд тусдаа орон тооны хүн байхгүй тул аймаг, орон нутгийн ХГБХХГ-ын мэргэжилтнүүд өөрийн үндсэн ажил дээр нэмж, үйлчилгээ үзүүлж байна. Гэвч хариу үйлчилгээг хүүхдийн хэрэгцээнд нийцүүлэн нарийвчлан тодорхойлох, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, тэнд ажиллах хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх, чадавхжуулах, мэргэшүүлэх, хохирогч төвтэй үйлчилгээг нэвтрүүлэх хэрэгцээ зайлшгүй шаардлагатай байна.

Сайн жишээ: Бат-Өлзий суманд “Түр хамгааллын байр”-тай болж үйл ажиллагаа явуулж байгаа нь сайшаалтай байна. Тус хамгаалах байрны зардлыг сумын орон нутгийн төсвөөс зарцуулж ирсэн байна.

2.2.5 Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн хувь хүний нууц бүрэн хамгаалагдаагүй байна.

Аймаг, сум болон сургуулийн нийгмийн ажилтнууд хүүхдийн кейс хадгалах төмөр сейф, лац тэмдэггүй, кейс бүртгэлийн дэвтэргүй байна. Энэ нь кейс алдагдах магадлалтай байна.

Кейс бүр дээр хувийн хэрэг нээж маягтын дагуу бүртгэлийг хөтөлж, төлөвлөгөө гарган хамгааллын үйлчилгээ үзүүлсэн байна. Кейс бүрийг коджуулж ажиллаад зарим хаасан кейсүүдээ архивлан аймаг, орон нутгийн ХГБХХГ-т хүргүүлсэн байна.

Маягтын дагуу хүүхдийг бүртгэж, гэр бүлд нь нөхцөл байдлын үнэлгээ, хүүхдийн эрсдэлийн үнэлгээ хийж, үйл явцын тэмдэглэл, ярилцлагын тэмдэглэл үйлдсэн байна. Цаашид ажиллах шаардлагагүй гэж үзсэн кейсээ маягтаар хаасан байна.

⁵ 38.1.2.хүүхэд хамгааллын санхүүжилт, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардлыг орон нутгийн төсөвт жил бүр тусгаж батлах;

Хамтарсан багийн бүх гишүүдтэй Нууцын гэрээ байгуулаагүй, Кейсийг нууцын бичиг баримт гэж үзэж бүртгэн хадгалаагүй зөрчил ихэнх сумдад байна.

Кейсийн бүртгэлийн дэвтэр, нууц бичиг баримт хүлээлцсэн бүртгэл байхгүй байна.

2.2.6 Хүүхэд хамгааллын зардлыг 2019-2021 онуудад үйлчилгээний төрлөөр төлөвлөдөггүй байсан бол 2022-2023 онуудад зардлын ангиллаар нь төлөвлөж зарцуулсан байна.


Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор хүүхэд хамгаалах байранд ирсэн хүүхдийн хоолны зардлын нэгж бүрийн жишиг норм, норматив, тарифыг 2475 төгрөгөөр тогтоосон боловч аймгийн хүүхэд хамгаалах байрны хүүхдийн хоолыг норматив зардлаар тооцож өгөөгүй, өдөр тутмын хүүхдэд олгосон хүнсний анхан шатны баримт материал дутуу хөтөлсөн байна.

Хүүхдүүдэд өгсөн хоолны илчлэгийг тооцдоггүй, тухайн өдрийн хоолны цэсийн дагуу түүхий эд бүтээгдэхүүнийг олгодоггүй, бүртгэл мэдээлэл хөтөлдөггүй, хоолны чанар стандартын чанар, аюулгүй байдлын шаардлага хангахгүй байна. Иймд төсвийн зарцуулалт бодитой бус, үр ашиг, үр дүн багатай зарцуулагдах эрсдэлтэй байгаа нь харагдаж байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхэд хамгааллын үйл ажиллагааг санхүүжүүлэх тухай ерөнхий заалт байгаа боловч төсвийн тухай хуульд хүүхэд хамгааллын санхүүжилттэй холбоотой хууль эрх зүйн орчин хангалтгүй байна.

Улсын төсвөөс 2019-2021 онуудад олгосон хүүхэд хамгаалах зардлыг нийт зардлын дүнгээр төлөвлөж байсан бол 2022-2023 онуудад зардлын ангиллаар нь төлөвлөж зарцуулсан байна. Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 5 жилээр харуулбал /сая.төгрөг/

График-2 Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл 2019-2023 он



Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын санхүүгийн мэдээлэл


Дээрх графикаас харахад хүүхэд хамгаалах зардал 2022, 2023 онуудад нэлээд өссөн байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний урьдчилсан сэргийлэх арга хэмжээнд аймаг, сумдын орон нутгийн төсвөөс мөнгө хуваарилаагүй байна. Харин Арвайхээр сум 2023 оноос эхэлж 20.0 сая төгрөг төлөвлөж урьдчилан сэргийлэх арга хэмжээнд үр дүнтэй зарцуулсан байна.

Хүүхдийн хүчирхийлэл жил бүр нэмэгдэж байгаатай уялдан хүүхэд хамгааллын зардлыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэхэд анхаарах, эцэг эхийн ухамсар, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулах шаардлагатай байна. Тухайлбал:

Хүснэгт-8 Насанд хүрээгүй хүүхэд хохирсон бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо

Онууд	2019	2020	2021	2022	2023
Нийт хүүхдийн тоо	43650	42276	42676	42621	42621



Насанд хүрээгүй хүүхэд хохирсон бэлгийн хүчирхийлэл	10	9	18	12	13
Нийт хүүхдэд эзлэх хувь	0.02	0.02	0.04	0.03	0.03

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээлэл

Дээрх судалгаанаас харахад насанд хүрээгүй хүүхэд хохирсон, бэлгийн хүчирхийлэл өртсөн хүүхдийн тоо жил тутам нэмэгдсэн байна. Хүчирхийллийн хохирогч хүүхдийн гол нөхцөл шалтгаан нь гэр бүлийн орчин нөхцөл, аав ээжийн үл хайхрах байдлаас болж үүсэж байна.

Тухайлбал: Ураг төрлийн болон ойр дотнын хүндээ хүчиндүүлсэн тохиолдолд хуулийн байгууллагад мэдээлдэггүй, мэдээлсэн ч томчууд хоорондоо “тохиролцоод” хүүхэд хохироод үлдсэн асуудал гарч, эмнэлгийн үзлэгээр илэрч, хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

БҮЛЭГ-3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГАЧЛАЛ БАЙХГҮЙ Ч СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙГДСЭН БАЙНА.

3.1. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжиж буй үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо бүрдээгүй байна.

3.1.1 Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх салбарын онцлогт нийцсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлал байхгүй байна.

Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч тал нь маш өргөн хүрээтэй бөгөөд дараах оролцогч талууд байна. Үүнд:


- Төрийн байгууллага
- ТББ
- Иргэд
- Хэвлэл, мэдээлэл

Хүүхэд хамгааллын салбарт ажиллаж буй байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хуульд заасан үндсэн үйл ажиллагаа зэргийг үндэслэн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнасан байдлаар үнэлж дүгнэж байна. Шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төлөвлөгөөнд тусгаж байгаа боловч үнэлэх нарийвчилсан аргыг тусгаж өгөөгүй байна. Аймгийн ХГБХХГ-аас 2019, 2021-2023 онуудад хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллагааны хэрэгжилтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулж 75-85 хувьтай дүгнэгдэж байжээ. Гэвч оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлэх салбарын онцлогт нийцсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлал байхгүй байна.

3.1.2 Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн талаар судалгаа шинжилгээ, нөхцөл байдлын үнэлгээ хийгдэж байна.

Тус аймагт хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдлын судалгаа шинжилгээг 2018 оноос хойш хийсэн байна. Жишээ нь:

Эрх зөрчигдөж болзошгүй нөхцөл байдлыг тогтоох, эрх нь зөрчигдсөн тохиолдлыг шийдвэрлэхэд аймгийн Ерөнхий боловсролын сургуулиуд, Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газрууд голлон салбарын нөхцөл байдлын үнэлгээг хийж байна. Урьдчилан сэргийлэх тандалт судалгаа хийх, хүүхэд гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсны дараах илэрсэн нөхцөл байдалд гэр бүлийн орчин, гэр бүл салалтаас үүдэлтэй байгааг судалгааны нэгтгэлд онцолсон байна.



Боловсролын орчин дахь үе тэнгийн дарамт дээрэлхэл нэмэгдэж байгааг салбарын асуудал хариуцсан газар, цагдаагийн газрын хийсэн хяналтаар илрүүлсэн байна.

Судалгаа шинжилгээ хийж илэрсэн нөхцөл байдалд тулгуурлан урьдчилан сэргийлэх сургалтыг хүүхэд, гэр бүлийн гишүүдэд зориулан 2021 оноос тогтмол хийж байна. Орон нутагт хэрэгжүүлж буй хүүхэд хамгааллын бодлогыг хүүхдийг хохирогч болсны дараах ажилд голчлон хэрэгжүүлж байна.

Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газраас 2023 онд салбарын бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд хяналт-шинжилгээ хийж ажилласан нь хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд чиглэсэн үр дүнтэй ажил болсон байна.

3.1.3 Хүүхэд хамгааллын чиглэлээр Олон Улсын байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмжөөс зарим асуудлын биелэлтийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Нэгдсэн үндэсний байгууллагаас 2017 онд Хүүхдийн эрхийн Конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 5-р тайлан илтгэлтэй холбогдуулан НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол улсад хүүхдийн асуудалтай холбоотой төсөв, нөөцийн хуваарилалт, бизнесийн салбар ба хүүхдийн эрх, үл ялгаварлах, гэр бүлийн орчин, орчны эрүүл мэнд, хүүхдийн хөдөлмөр болон унаач хүүхдийн асуудлыг багтаасан эдийн засгийн мөлжлөг зэрэг зөвлөмжүүдийг өгсөн байдаг.

Судалгаагаар аймгийн хэмжээнд тэвчишгүй хөдөлмөр эрхэлдэг 40 орчим хүүхэд байна. НҮБ-ын Монгол Улс дахь Удирдлагын багаас Засгийн газарт хандсан мэдэгдэлд Монгол Улсын Засгийн газрыг 18-аас доош насны хүүхдийг жилийн аль ч улиралд хурдан морь унуулж уралдуулахгүй байхыг хууль тогтоомж, зохион байгуулалтын үйл ажиллагаандаа тусган, шаардлагатай бүхий л арга хэмжээг нэн яаралтай авч хэрэгжүүлэхийг зөвлөсөн байдаг.

Сумын морин спорт, уяачдын холбоонд: МУЗГ-ын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоол, ХНХЯ-ны сайдын 2022 оны А/122 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн А/25 дугаар захирамжийн дагуу хурдан морины уралдааныг хориглосон хугацааг заасан байна. Хориглосон хугацаа дуусгавар болсон үед аймгийн хэмжээнд 2022 -2023 оны хувьд жилд дунджаар 654 орчим унаач хүүхэд бүртгэгдсэн тухай судалгаа гаргасан байна. Хориглосон хугацаанд уралдаан зохион байгуулсан удирдлагад арга хэмжээ авч ажилласан байна.


“Арвагар хээр” морин спорт уяачдын холбоотой хамтран уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, эцэг эх, уяачдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Уралдаанч хүүхдээ анхаарч хамгаалъя” анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулж, 220 уяач, уралдаанч хүүхэд, эцэг эхийг хамруулан, Морин спорт уяачдын холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгуулж, 500 ширхэг гарын авлагыг тараасан.

3.1.4 Хүүхэд хамгааллын чиглэлээр Олон улсын байгууллага, төрийн бус байгууллагаас хэрэгжүүлсэн, үйл ажиллагаа хөтөлбөрийн үр дүнг тооцсон тухай баримт материал байхгүй байна.

Аудитын явцад хүүхэд хамгааллын чиглэлээр олон улсын байгууллага, төрийн бус байгууллагаас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнг аймгийн хувьд дүгнэсэн баримт материал байхгүй байна.

3.1.5 “Хүүхэд хамгааллын бодлого”-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдээгүй байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд хамгааллын бодлого”-ын 2020-2024 он буюу 2 дугаар шатны хэрэгжилтийн явцыг аудитад



хамруулан авч үзлээ. Бодлогод тэргүүлэх 4 зорилт, дэд 28 зорилтыг тусгаж холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна. Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газраас 2023 онд бодлогын хэрэгжилтийг Хүүхдийн зөвлөлөөр хэлэлцүүлж 87 хувьтай дүгнэгдсэн байна. Гэвч “Хүүхэд хамгааллын бодлого”-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдээгүй байна.

3.1.6 Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал байхгүй байна.

Хүүхэд хамгааллын бодлогод тусгагдсан арга хэмжээний хүрэх үр дүнг бодит тоон үзүүлэлтэд тулгуурлан төлөвлөөгүй байна.

Төлөвлөсөн зорилтыг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг ерөнхий байдлаар тусгаж өгсөн нь үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг сайжруулах, боловсронгуй болгох ёстойг илэрхийлж байна.

Тэргүүлэх, дэд зорилтыг үнэлэхдээ арга хэмжээг хэрэгжүүлсэн байгууллагын тайлан, хамрагдсан хүүхдийн тоо, үйлчилгээ үзүүлсэн тоон мэдээлэлд үндэслэн үнэлж байна.

Бодлогын хэрэгжилтийн тайланд материаллаг /сургууль, дотуур байр, хамгаалах байр, зам, талбай тохижуулах зэрэг/ байдлыг сайжруулахтай холбоотой хийгдсэн ажлыг ихээхэн тусгажээ.

3.1.7 Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, зарим эерэг үр нөлөө бий болсон байна.

Хүүхэд хамгааллын бодлого, мэргэжлийн байгууллагуудаас зохион байгуулсан хөтөлбөр, аян, кейс шийдвэрлэлтийн явцад хамтарсан багуудаас авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнд зарим эерэг үр нөлөө бий болсон байна. Тухайлбал:

- Аймгийн Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газрын хамтран хэрэгжүүлсэн “Хүүхэд хамгаалалд-Бидний оролцоо” аяны хүрээнд өсвөр насны хүүхдүүдийг гэмт хэрэг зөрчилд холбогдох, өртөхөөс урьдчилан сэргийлсэн ажил
- Хамтарсан багийн ажлын үр дүнд архины хамаарал бүхий 11 иргэнийг сэтгэл зүй, архины эмчилгээнд хамруулан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн
- Гэр бүл салалтаас үүдэлтэй үл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд үзүүлж буй нэг цэг, хамгаалах байрны үйлчилгээ үзүүлсэн
- Хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой зөрчлийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлсэн
- Хүмүүжлийн шинж чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 41 хүүхдэд үзүүлсэн сэтгэл зүй, хууль зүйн үйлчилгээ гэх зэрэг эерэг үр дүн бүхий ажлууд гарсан байна.



3.2. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ нь үр нөлөөгөө өгч эхэлж байна.

3.2.1 Гэр бүлийн орчинд чиглэсэн урьдчилсан сэргийлэх арга хэмжээ хүртээмж муутай байгаагаас шалтгаалан гэр бүлийн орчин дахь хүүхдийн хүчирхийллийн тоон үзүүлэлт буурахгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай /2016 оны/ хуулийн 5 дугаар зүйл⁶, 19 дүгээр зүйл⁷; Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлд⁸ Гэр бүл дэх хүүхэд хамгааллын талаар эцэг эх, асран хамгаалагч болон бусад холбогдох байгууллага, салбарын нийгмийн ажилтнуудын үүргийг заасан байдаг. Өвөрхангай аймгийн ХГБХХГ-с гэр бүлд чиглэн 2019-2023 онд хийгдсэн урьдчилан сэргийлэх, нөлөөллийн үйл ажиллагаануудаас дурдвал. Үүнд:

- “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургалт багш /ангийн, дотуур байрны, биеийн тамирын, өдөр өнжүүлэх төвийн багш нар, эцэг эхчүүдэд/
- “Гэр бүлийн зөвлөл” байгуулсан- төрийн 144, хувийн хэвшлийн 27, ААН 171 нэгжийн дэргэд
- Цагдаагийн газартай хамтарч “Хаалга” сарын аян /Иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, цахим орчинд гэр бүлийн зүй зохистой, эерэг харилцааг сурталчлах зорилготой/
- Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах чиглэлээр хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулсан-Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран 645 айл өрх, 37 ААН
- “Хэрсүү гурвалжин” нөлөөллийн арга хэмжээ/ хүчирхийллийг илрүүлэхэд тэдний үүрэг оролцоо чухал гэдгийг ойлгуулах/-53 дэлгүүрийн худалдагч, 26 худгийн ус түгээгч, 71 хөршид танхимын хэлбэрээр сургалт зохион байгуулсан.
- “Хүчирхийлэлгүй нийгмийг бүтээе” төсөл
- Олон Улсын Гэр бүлийн өдөр-гэр бүлийн талаарх 6 цуврал хэлэлцүүлгийг зохион байгуулсан
- “Эцэг, эхийн зөвлөл”-ийг байгуулсан-19 сумын 170 байгууллагын дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулагдаж, 500 орчим хүн гишүүнээр ажиллаж байна.
- Миний гэр бүл, миний аз жаргал” телевизийн ток шоуг хийж түгээсэн- Орон нутагт үлгэр жишээ болсон залуу, дунд, ахмад 3 үеийн төлөөлөл 13 гэр бүлийг оролцуулсан
- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөрийн хүрээнд цагдаагийн газартай хамтран 19 суманд ажиллаж, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, хүлээх хариуцлага”, “Эцэг, эхийн үүрэг хариуцлага”, “Хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн үүрэг, оролцоо” сэдвүүдээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан
- “Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг олон улсын өдөр”, “Олон улсын гэр бүлийн өдөр”, “Аавуудын баяр”, “Ахмадын баяр” - зэрэг тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулсан 70 арга хэмжээ
- “Хөөрхөн зүрх”, “Ундраа Ужин”, “Сэтгэлийн өнгө”, “Галт шувуу” зэрэг төрийн бус байгууллага, Монголын Урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбоо, Олон Улсын Улаанбаатар их сургууль, Японы хүүхдийг ивээх сан зэрэг байгууллагуудтай хамтран 28 нөлөөллийн үйл ажиллагаа
- Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран гэрлэлтийн гэрчилгээ гардуулах ёслол, Насан туршийн боловсролын төвтэй хамтран “Аз жаргалтай гэр бүл” вакум сургалт, “Эцэг эхийн зөвлөл”-үүдтэй хамтран гэр бүлийн боловсрол олгох сургалтуудыг үе шаттай зохион байгуулсан
- “Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн зөвлөгөөн”- Аймгийн Гэмт хэргээс

⁶ 5.1.Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээг авна.

5.2.Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд өсөж хөгжих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хуульд заасны дагуу эвлэлдэн нэгдэх, шаардлага, өргөдөл, гомдол, мэдээлэл гаргаж, түүнийг шийдвэрлүүлэх замаар хүүхэдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

5.3.Гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн хүүхэдэд үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу үзүүлнэ.

5.4.Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хамаатан садан, багш сургаан хүмүүжүүлэгч нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэнэ.

⁷ 19.1.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг судлан тогтоох, бүртгэх, тэдний эрх ашгийг хамгаалах, хариу үйлчилгээнд хамруулах;

19.1.2.Хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлах, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх,

⁸ 26.1.6.гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах;

26.2.3.гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурагч, багш, боловсролын байгууллагын бусад ажилтан, эцэг, эхэд мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах;

- “Бүх хайрыг гэр бүлдээ” сургалт-Залуу гэр бүлүүдэд зориулсан сургалтыг 2 сарын хугацаанд үе шаттай зохион байгуулсан
 - Хүүхэд хөгжлийн өрөөтэй 16 байгууллага байснаас 2023 онд 8 байгууллага нэмэгдсэн
- урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Цагдаагийн газар, Үндэсний сургагч багш Д.Ундраатай хамтран 5 суманд зохион байгуулсан

Хүснэгт-9 Урьдчилан сэргийлэх, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн тоо

№	Үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн тоо	2019	2020	2021	2022	2023
1	Иргэн	890	1070	1200	836	3300
2	Хүүхэд	10506	12456	8790	9628	17655
3	Гэр бүл	40	63	81	145	629
Нийт дүн		11436	13589	10071	10609	21584

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээлэл

Хүснэгт-10 Өвөрхангай аймгийн хүн амын тоо болон 0-18 нас хүртэлх хүүхдийн тоо

№	Тоон үзүүлэлтийн ангилал	2018	2019	2020	2021	2022	2023
1	Хүн амын тоо	116645	114785	116785	117261	117089	115757
2	Хүүхдийн тоо	43630	43218	44007	44317	44391	43668
3	Өрхийн тоо	34652	33062	33700	34424	34436	34448

Эх сурвалж: Статистикийн 1212.mn сайт, аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээлэл

Дээрх хүснэгтэн мэдээллүүдийг харьцуулан үзэхэд нийт хүүхдийн 2019 онд 24%, 2020 онд 28%, 2021 онд 19%, 2022 онд 21%, 2023 онд 40%-д урьдчилан сэргийлэх, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан байна. Хамрагдсан гэр бүлийн тоо харьцангуй бага байна.

Газрын дэргэдэх Зөвлөгөө өгөх өрөөг Гэр бүлийн зөвлөгөө өгөх төвд тавих нийтлэг шаардлагын /MNS6417:2013/ дагуу тохижуулахаар Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллагад хандсан төсөл дэмжигдсэнээр 2019 онд зөвлөгөө өгөх өрөөг тохижуулан ажиллуулж эхэлсэн. Тус өрөөний тохижилт стандартад бүрэн нийцээгүй хананы өнгө хурц тод, эрээн; хөгжим, тайвшруулах ая бүхий CD болон бичлэг, амьд цэцэг, ажиллах цагийн хуваарь, байгууллагын үйлчилгээний зорилго, дотоод журам зэргийг өрөөнд байрлуулаагүй байна. Мөн цахимаар, утсаар үйлчилгээ үзүүлсэн хүмүүсийн бүртгэл байхгүй байна.

Хүснэгт-10 Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоо:

№	Зөвлөгөөнд хамрагдсан иргэдийн төрөл	2019	2020	2021	2022	2023
1	Иргэн	57	187	159	380	154
2	Хүүхэд	41	123	115	251	254
3	Гэр бүл	20	25	42	35	30
Нийт дүн		118	335	316	666	438

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээлэл

Эрсдэлтэй гэр бүл рүү чиглэсэн 2019-2023 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудаас дурдвал. Үүнд:

- “Гэрээр айлчлагч” нар сумдын мэргэжилтнүүд, багийн нийгмийн ажилтнуудтай хамтран аймгийн хэмжээнд “Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-т хамрагдаж байгаа Арвайхээр сумын 154 өрх, бусад сумдын 116 өрх нийт 270 өрхийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон нөхцөл
- 2020 онд нийт 93 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийн, өрхийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл болон шаардлагатай эм, хүнсний багцыг хүргэж ажилласан. Мөн 192 хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээнээс үзэхэд, эрүүл мэндийн

байдлын үнэлгээг хийж, өрхийн гишүүн бүрд хүрч ажиллах цогц үйлчилгээг хэрэгжүүлэх ажлын чиглэлийг тодорхойлон ДЗОУБ-ын Өвөрхангай ОНХ-тэй хамтран ажилласан. 12 төрлийн хэв шинжээр зорилтот 270 өрхийг сонгон нийгмийн нөхөн сэргээх үйлчилгээнүүдийг хүргэсэн байна.

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр батлах тухай” хөтөлбөрийн хүрээнд Хорихоос суллагдсан 33, архины хамааралтай 334 иргэнийг судалгааг нэгтгэж, судалгааны сан бүрдүүлээд байна. Судалгаанд хамрагдсан иргэдээс архины хамааралтай 220 гэр бүлийг сонгон нөхцөл байдлын үнэлгээ хийж, СӨБ-д хамрагдаагүй 7 хүүхдийг холбон зуучилж харъяа цэцэрлэгт хамруулж, өвлийн хувцас байхгүй 8 хүүхдэд дулаан хувцас өгч, халамжийн үйлчилгээнд хамрагдах нэн шаардлагатай 4 өрхийг халамжийн нийгмийн ажилтантай холбон зуучилж, 15 гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, 22 гэр бүлийг гэр бүлийн боловсрол олгох “Гэр бүлийн харилцаа”, “Гэр бүлийн эрүүл мэнд” сэдэвт сургалтад хамруулж хариу арга хэмжээ авч ажиллаж байна.

үйлчилгээ шаардлагатай 12, боловсролын үйлчилгээнд 13, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай 4, халамжийн үйлчилгээнд хамруулах 6, хууль зүйн үйлчилгээнд хамруулах 9 хүүхэд байгааг тогтоон холбогдох байгууллагуудад холбон зуучилж, үйлчилгээ үзүүлсэн.

- “Багш айлчлал” ажлын хүрээнд хийгдсэн судалгаанд үндэслэн эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа өндөр эрсдэлтэй хүүхэд тэдний гэр бүл, гэр бүлийн туршилтын хөтөлбөрт хамрагдаж байгаа гэр бүлүүдэд зориулсан сургалт нөлөөллийн ажлыг давтамжтай зохион байгуулж байна. Гэр бүлийн боловсрол олгох сургалтад гэр бүлийн туршилтын хөтөлбөрт хамрагдаж буй 203 өрхийн гишүүд, өндөр эрсдэлтэй 154 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч хамрагдаж, гэр бүлийн эрүүл харилцааг эрхэмлэн, гэр бүлээ аз жаргалтай, амар тайван байлгах, гэр бүлийн үнэ цэнийг ойлгож, дээдлэхэд суралцсан.
- 2023 онд газрын дэргэдэх зөвлөгөө өгөх өрөөгөөр үйлчлүүлсэн гэр бүлээс 10 гэр бүлийг тогтмол сэтгэл зүйн үйлчилгээнд, 5 хосыг эвлэрүүлэн зуучилж, өрх тусдаа амьдарч байсан 8 хосыг эргэн нэгтгэж, хорт зуршилтай 11 гэр бүлийн эмнэлзүйн оношийг үндэслэн, сэтгэцийн эмчтэй хамтран сэтгэл заслын үйлчилгээнд хамруулан ажилласан.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо, кейс нээсэн тоо, үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоон үзүүлэлтүүдийг авч үзвэл:

Хүснэгт-11 Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо, дуудлагын тоо

№	Огноо	Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил- Дуудлагын тоо /108/	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо	Кейс нээн шийдвэрлэсэн тоо
1	2019	33	52	45
2	2020	49	65	52
3	2021	82	111	84
4	2022	84	125	87
5	2023	90	145	95
Нийт дүн		338	498	363

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээлэл

Аудитын явцад хамтарсан багуудын илрүүлэлтээр гарсан зөрчил, кейсийн бүртгэл, тоон мэдээллээр бүрэн хангагдаж чадаагүй тул зөвхөн 108 утасны дуудлага мэдээллийн тоог ашиглав.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 2019-2023 онд ирүүлсэн нийт 446 дуудлага мэдээллийн ихэнх хувийг Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил эзэлж байгаа бөгөөд дээрх хүснэгтээс харахад 2021-2023 зөрчлийн тоо жигд өсөлттэй байна.

Хүснэгт-12 Гэр бүлийн хэрэг, зөрчлийн мэдээлэл

№	Он	Бүртгэгдсэн гомдол мэдээлэл
1	2019	164
2	2020	192
3	2021	140



4	2022	304
5	2023	235
Нийт дүн		1035

Эх сурвалж: Аймгийн Цагдаагийн газрын статистик мэдээлэл

Цагдаагийн газраас ирүүлсэн тоон мэдээллээс харахад бүртгэгдсэн гомдол мэдээллийн тоо 2022-2023 онд огцом өссөн байна.

Хүснэгт-13 Гэрлэлт ба гэр бүл цуцлалтын мэдээлэл 5 жилээр

№	Гэрлэлт ба гэр бүл цуцлалт	2019	2020	2021	2022	2023
1	Гэрлэлт	545	543	608	414	353
2	Гэр бүл цуцлалт	75	78	72	92	85

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээлэл

Дээрх хүснэгтээс харахад сүүлийн 2 жилийн хугацаанд гэрлэлт буурсан ч салалтын тоо өссөн байдалтай байна. Энэ нь хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйл болж байна.

Урьдчилан сэргийлэх, нөлөөллийн үйл ажиллагаа төрөл бүрээр хийгдэж байгаа ч хамрагдалт хангалтгүй, илүү олон тооны иргэдийг нөлөөллийн ажилд хамруулах шаардлагатай байгааг дээрх нөхцөл байдлуудаас дүгнэн харж болно. Иргэд, хүүхдүүд өөрийн эрхийн талаар илүү мэдлэгтэй болсноос үүдэлтэй 108 утас, ХГБХХГ, хамтарсан багуудад иргэдийн эрхээ хамгаалуулах талаар хандах тоо ихэссэн байна.

Гэр бүлийн зөрчил ихсэж байгаа нь урьдчилан сэргийлэх, нөлөөллийн үйл ажиллагаа үр дүн хангалтгүй, нөгөө талаасаа гэр бүл төлөвшлийн асуудал их байгаа зэргээс шалтгаалж байна.

Боловсролын орчин дахь зөрчлийн тоо сүүлийн жилүүдэд өссөн байна. Энэ нь сургуулиудын үйл ажиллагаа, нийгмийн ажилтан, дотуур байрны үйл ажиллагаатай холбоотой байгаа боловч нөгөө талаас үүнд нөлөөлж байгаа нэг хүчин зүйл нь хүүхдүүдийн хүмүүжил, төлөвшилтэй холбоотой асуудлууд юм. Тухайлбал: Далд хэлбэрийн гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх талаар илүү сайн анхаарч ажиллан сургуулийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудтай нягт хамтран ажиллах шаардлага үүсээд байна.

Иймд гэр бүлийн орчинд нөлөөллийн ажил явуулах цар хүрээг ихэсгэх шаардлагатай байна.

3.2.2 Боловсролын салбар эрсдэлийг тодорхойлох тал дээр ахицтай сайн жишээ болохуйц ажил хийгдэн нийт суралцагчдын эрсдэлийг бүрэн үнэлж байгаа боловч хүүхэд хамгаалалтай холбоотой зөрчлийн шийдвэрлэлт, эрсдэлтэй хүүхдүүдтэй ажиллах, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх тал дээр дутмаг байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/476 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого”-ыг баталж; Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/453 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого”-ыг ахин шинэчлэн баталсан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/269 дүгээр тушаалаар “Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого”-ыг баталсан байна.

Хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газраас 2019-2023 онуудад тогтмол арга зүйн зөвлөмж, чиглэлийг өгч, туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлгүүд зохион байгуулж зарим судалгааны ажлуудыг хийжээ. Тухайлбал:


Хийгдсэн ажил /зорилго, үр дүн/, хамрагдсан оролцогчид	
“Дотуур байр-Хүүхдийн хөгжлийн орчин”, “Дотуур байрын суралцагчийн эрх, хамгаалал, аюулгүй байдал” аймгийн зөвлөгөөн	19 сумдын Засаг дарга нар, дотуур байртай 19 сургуулиудын захирлууд, 32 дотуур байрны багш нар, дотуур байртай 19 сургуулиудын нийгмийн ажилтнууд, 5 зохион байгуулагч
“Бага насны хүчирхийллээс ангид байх орчныг дэмжих нь” төсөл	19 сумын 31 цэцэрлэгийн 40 гаруй аргазүйч болон багш нарыг сургагч

	багшаар бэлтгэж, аймгийн хэмжээнд 6800 гаруй эцэг эх, 750 багш, ажилтанд сургалтыг зохион байгуулсан.
Гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, илрүүлэх чиглэлээр чадавхжуулах сургалт	Багш, ажилтан, албан хаагчдад
Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор баталсан “School police”	Ерөнхий боловсролын сургууль, түүний орчинд сурагчид гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөх, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилготой
Аймгийн хэмжээнд дотуур байранд амьдарч буй сурагч, түүний эцэг эхтэй сургуулийн захиргаанаас гэрээг байгуулж ажиллаж хэвшсэн байна.	Сургуулийн захиргаа, байрны багш, эцэг эх, асран хамгаалагч болон сурагчийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой
“Сургуулийн орчин дахь үе тэнгийн дээрэлхэлтийн өнөөгийн байдал, түүнийг таслан зогсоох арга зам” сэдэвт судалгааг хийсэн	Эцэг эх асран хамгаалагч ойлголт дутмаг, багш сурган хүмүүжүүлэгчдийн дарамт дээрэлхэлтэнд өртсөн хүүхэдтэй ажиллах арга барил хангалтгүй байна гэсэн дүгнэлт гарсан
2019-2020 оны хичээлийн жилд ЕБ-ын 31 сургуулийн Хүүхэд хамгааллын бодлогыг татан авч, хяналт шинжилгээ хийсэн	Зөвлөмж өгч, сургалт хийсэн
Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд илэрч буй сэтгэц, зан үйлийн өөрчлөлт нөхөн сэргээх арга зам; Өсвөр үеийнхний дундах амиа хорлох, амиа хорлох оролдлого хийх төрх үйлийн тархалт-илрүүлэг, урьдчилан сэргийлэх арга зам; Анги удирдсан багш нарын хүүхдийн сэтгэл зүйн онцлогийн талаарх мэдлэг ойлголт-дэмжлэг үзүүлэх арга зүй; Эцэг эх, асран хамгаалагчийн хүүхдийн сэтгэл зүйн онцлогийн талаарх мэдлэг ойлголт-дэмжлэг үзүүлэх арга зүй сэдэвт Асуудал, шийдэл эрдэм шинжилгээ, судалгааны ажлын уралдаан	31 сургуулийн сурагчид, тэдний эцэг эх, асран хамгаалагчид, багш сурган хүмүүжүүлэгч, ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулсан
“Хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн асуудал, эрсдэлийг илрүүлэх судалгаа”, Гэмт хэргийн хохирогч хүүхдийн сэтгэл зүйн байдлын талаар судалгаа хийгдсэн.	
Хүүхдийг цахим орчинд хамгаалъя үйл ажиллагааг зохион байгуулсан.	

ЕБС-ын дотуур байрны орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, дотуур байрны үйл ажиллагааг сайжруулах, албан хаагчдын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, эцэг эх, багш, ажилтны хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 2021 оны А/31 дүгээр тушаалаар “Сургалтын орчин, дотуур байранд теле хяналтын камер ашиглалтын үлгэрчилсэн журам”, 2021 оны А/41 дүгээр тушаалаар “ЕБС-ын дотуур байранд амьдарч байгаа сурагчийн эцэг эх, асран хамгаалагчтай байгуулах хариуцлагын гэрээний жишиг загвар” “Дотуур байрны жижүүрийн өдөр тутмын тэмдэглэл хөтлөх жишиг загвар”, “Дотуур байранд гаднын хүн нэвтрэхэд хөтлөх бүртгэлийн жишиг загвар”, “Дотуур байрны сурагчийг эцэг эх асран хамгаалагчдад гараас гарт хүлээлгэн өгөх бүртгэлийн жишиг загвар”-ыг тус тус батлан, холбогдох байгууллагуудад хүргүүлэн хяналт тавьж ажилласан.

Аймгийн Боловсролын газраас 2019-2023 багш, сурагчдад хүүхэд хамгааллын чиглэлээр мэдээлэл хүргэх, чадавхжуулах сургалт, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулсан байна.

Сайн туршлага: Дэлхийн зөн ОУБ-ын хэрэгжүүлж байсан Гэрээр айлчлагч хөтөлбөрийг боловсролын салбарт “Багш айлчлал аргачлал” гэх нэртэйгээр 2017 оноос хэрэгжүүлж, тогтвортой, үр дүнтэй нутагшуулж байна. Тус аргачлалын зорилго нь “Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын оролцоотойгоор суралцагчдын ар гэрийн орчин



нөхцөлд аргачлалын дагуу үнэлгээ хийж, хүүхдийг гэр бүлийн болон үе тэнгийн дээрэлхэл, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллыг бэхжүүлэх, хүүхдийг хөгжил, төлөвшлийг сайжруулж, гэмт хэрэг зөрчилд холбогдох, хохирох явдлыг бууруулах, эдгээр үйл ажиллагаанд эцэг эх асран хамгаалагч, салбар дундын үүрэг оролцоог нэмэгдүүлж, бүтээлч хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгддэг.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/131дүгээр захирамжаар Багш айлчлал аргачлалыг дахин шинэчлэн боловсруулах ажлыг хэсэг байгуулж, вэб болон аппликейшинд суурилсан эрсдэлийн үнэлгээний программтай болсон байна. Үүний үр дүнд:

- Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн тоо нэмэгдсэн /4 орчны хүрээнд 23 шалгуур үзүүлэлтээс 53 шалгуур үзүүлэлт болсон/
- Багш сурагчийн мэдээллийг хурдан шуурхай бүртгэх
- Суралцагчийн мэдээллийг архив үүсэж, анги дэвшилт, шилжилт хөдөлгөөн хийхэд эрсдэлийн мэдээлэл хадгалагдах боломжтой
- Хувь хүний болон гэр бүлийн мэдээллийн нууц хадгалагдах
- Хамгааллын үйлчилгээг үзүүлэх талуудын оролцоог илүү нарийвчлан тодорхойлох зэрэг боломжууд бүрдэж, суралцагчдыг өртөж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүртээмж, чанарыг нэмэгдүүлэхэд үр дүнгээ өгч байгаа.

Энэхүү аргачлал, программ нь орон нутгийн байгууллагын санаачилгаар зөвхөн Өвөрхангай аймагт хэрэгжиж буй бөгөөд боловсролын салбарт үндэсний хэмжээнд сайн туршлага болоод байна.

Вэб аппликейшинд суурилсан программыг ашиглалтад оруулахад орон нутгаас 3 сая төгрөгийг зарцуулж, ашиглалтын болон домэйн эрх төлбөрийг аймгийн Боловсролын газраас шийдвэрлэн ажиллаж байна. /900 000 орчим төгрөг/

“Багш айлчлал аргачлал”-р Өвөрхангай аймгийн нийт ЕБС-уудын сурагчдын эрсдэлийг үнэлсэн байдлыг 2019-2023 оны байдлаар харуулбал:

Хүснэгт-14 “Багш айлчлал аргачлал”-р тодорхойлсон эрсдэлийн судалгаа

№	Огноо	Эрсдэлгүй	Бага эрсдэлтэй	Дунд эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй
1	2019-2020	14729	854	107	504
2	2020-2021	21133	1156	456	497
3	2021-2022	20054	1353	368	626
4	2022-2023	7680	9048	1555	1180
5	2023-2024	8684	9747	1952	1389

Эх сурвалж: Аймгийн Боловсролын газрын статистик мэдээлэл

“Багш айлчлал” аргачлалаар Өвөрхангай аймгийн хэмжээнд нийт ЕБС-д суралцагчдын эрсдэлийг тооцсон 2019-2023 оны тоон үзүүлэлт /2022, 2023 онуудад өндөр эрсдэлтэй хүүхдийн тоо өссөн нь аргачлалын шалгуур үзүүлэлт өөрчлөгдсөнтэй холбоотой/.

Зарим сургуулийн нийгмийн ажилтнуудын хувьд сурагчдаа танин мэдэх, эрсдэлийг илрүүлэх, зөрчил дутагдлыг засан сайжруулахын тулд сурагчидтай тогтмол бүлгийн болон ганцаарчилсан уулзалтыг хийх гэх мэт олон төрлийн үйл ажиллагааг явуулсан байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын хувьд эрхлэгчийн тушаалаар “Хүүхэд хамгааллын бодлого”, “Хүүхэд хамгааллын баг”-г бүрэн томилсон мөн эрсдэлтэй хүүхдийн судалгаануудыг гарган, төлөвлөгөө боловсруулж ажилласан байна. Гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, мэдээллийн ил тод байдлыг ханган Хүүхэд хамгааллын мэдээллийн самбарыг тогтмол шинэчлэн мэдээллийг хүргэж, эцэг эхчүүдийг хүүхэд хамгааллын талаар мэдээллээр ханган, харьяалах хамтарсан багуудтай хамтран ажиллаж байна. Мөн багш айлчлал хөтөлбөрийг СӨБ-д хийж эхэлсэн байна.

Зураг-1 Хужирт, Бат-Өлзий сумдын цэцэрлэгийн хүүхэд хамгааллын мэдээллийн самбар



Өвөрхангай аймгийн хэмжээнд 2019, 2020 онуудад нийт ЕБС-уудад 33 нийгмийн ажилтан ажиллаж байсан бол 2021-2023 онд 36 нийгмийн ажилтны орон тоотойгоор ажилласан байна. 2023 оны байдлаар Төгрөг сумын ЕБС-д нийгмийн ажилтны орон тоог газар зүйн багш хавсран гүйцэтгэсэн; Нарийнтээл, Сант сумдад Монгол-англи хэлний багш, Монгол хэл-Уран зохиолын багш нийгмийн ажилтны албан үүргийг гүйцэтгэн ажилласан байна.

Хүснэгт-15 Өвөрхангай аймгийн ЕБС-уудын сэтгэл зүйчдийн судалгаа

№	Он	Батлагдсан орон тоо	Орон тоогоор ажилласан тоо
1	2019	0	0
2	2020	0	0
3	2021	1	1
4	2022	5	5
5	2023	8	8

Эх сурвалж: Аймгийн Боловсролын газрын мэдээлэл

Сургуулиуд орон тооны сэтгэл зүйчтэй болсноор хүүхэд хамгааллын чиглэлээр тодорхой ахицууд гарч эхэлсэн. ЕБС-ийн сэтгэл зүйчдийн явуулын үйлчилгээг 7 сумдад зохион байгуулж, 886 сурагчийг бүлгийн ярилцлага, сургалтад, 175 суралцагчийг ганцаарчилсан зөвлөгөөнд, 114 эцэг эх, асран хамгаалагч, 450 багш сурган хүмүүжүүлэгчийг сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд хамруулсан байна. Арвайхээр суманд Сэтгэл зүйчдийн өдөрлөг арга хэмжээг ерөнхий боловсролын сургуулиуд дээр нээлттэй зохион байгуулсан байна.

Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалалтай холбоотой 108 утсанд ирсэн дуудлагын тоо 2019-2023 оны байдлаар:

Хүснэгт-16 Боловсролын салбар дахь 108 утасны дуудлага

№	108 дуудлагын /орчны төрөл/	2019	2020	2021	2022	2023
1	Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал	16	2	1	17	23

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээлэл

Дээрх дуудлагын тооноос харахад боловсролын салбар дахь хүүхэд хамгаалалтай холбоотой дуудлагын тоо өссөн байна.

Боловсролын байгууллагад дараах хяналт шалгалтыг хийж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Мэргэжлийн хяналтын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны нийт 6 ЕБС /Арвайхээр сумын “Тэмүүлэл-Эрдэм” сургууль, Хархорин сумын ЕБ-ын 2 дугаар сургууль, Нарийнтээл, Хайрхандулаан сумдын ЕБС, Нарийнтээл сумын Баянтээг багийн Бага сургууль, Тарагт сумын Туяа багийн Бага сургууль/,
- Боловсролын салбарын хяналтын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Өвөрхангай аймгийн Политехник коллеж болон сумдын ЕБС-ын 8 сургуульд /Баянгол, Төгрөг, Хужирт, Гучин-Ус, Есөнзүйл, Өлзийт, Бүрд, Хархорин “Номын хүрдэн” Ерөнхий боловсролын сургууль./ боловсролын хяналтын улсын байцаагч хяналт, шалгалтыг хийсэн.

- Хүний эрхийн үндэсний комиссын Өвөрхангай аймаг дахь салбараас 2023 онд Бат-Өлзий сумын дотуур байранд хяналт шалгалтыг хийсэн.
- ХГБХХГ-аас хүүхдийн эрхийн улсын байцаагч 2022 онд Богд сумын ЕБС, 2023 онд Хайрхандулаан сумын ЕБС-д төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн.

Дээрх хяналт шалгалтуудаар Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ үзүүлэх ерөнхий шаардлага /MNS 6781:2019/ стандартын хэрэгжилттэй холбоотой зөрчлүүд давтагдан их гарсан байна. Аудитаар талбар дээр ажиллахад дээрх хяналт шалгалтуудаар илэрсэн алдаа зөрчлүүд зарим сургуулиудад давтан гарсан, бүрэн засагдаагүй байна.

Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын байдлыг дүгнэн үзэхэд Боловсролын газрын зүгээс чадавхжуулах, нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол явуулдаг, эрсдэлийг тодорхойлох тал дээр ахицтай сайн жишээ болохуйц ажил хийгдсэн боловч хүүхэд хамгаалалтай холбоотой зөрчлийн шийдвэрлэлт, эрсдэлтэй хүүхдүүдтэй ажиллах, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх тал дээр дутмаг байна.

Аудитаар Арвайхээр, Хужирт, Бат-Өлзий, Хархорин, Зүүнбаян-Улаан сумдаар талбар дээр ажиллан шаардлагатай байгууллагуудын мэдээллийг татан үзсэн.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн:

- Хүүхэд хамгааллын бодлогоо өөрийн үнэлгээний загварын дагуу бүрэн үнэлдэггүй, хүүхэд хамгааллын багийн гишүүдийг шинэчлэн томилоогүй, багийн гишүүд Хүүхэд хамгааллын бодлогын талаар бүрэн мэдээлэл авсан эсэх нь тодорхой бус.
- Зарим сургуулиуд хүүхэд хамгааллын Урьдчилсан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө бүрэн бус
- Сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, сумын нийгмийн бодлогын ажилтнуудын ажлын уялдаа хангалтгүй, мэдээлэл бүрэн солилцдоггүй. /жишээ нь: сэтгэл зүйч эрсдэл илрүүлсэн боловч нийгмийн ажилтанд мэдэгдэж кейс нээдэггүй./
- Зарим цэцэрлэгүүд суралцагчдын эрсдэлийн судалгаа, гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээ бүрэн бус
- Өндөр эрсдэлтэй хүүхдүүдийг хамтарсан багт бүрэн шилжүүлдэггүй
- Сурагчдын зөрчлийн бүртгэлийг бүрэн хөтөлдөггүй.
- Кейс бүртгэл байхгүй. Зарим кейсийг нээсэн ч хаагаагүй орхисон. Кейсыг албан ёсоор бүртгэлжүүлж шилжүүлж хүлээлцдэггүйгээс үүдэн, кейс байгаа эсэх хамтарсан баг руу шилжүүлсэн эсэх нь тодорхой бус.
- Сурагчдын сэтгэл ханамжийн судалгаа, бусад судалгаа мэдээний үр дүнд бүрэн анализ хийдэггүй.
- Гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээний дагуу асуудлууд бүрэн шийдэгддэггүй
- Зарим нийгмийн ажилтнууд сурагчдын мэдээлэл судалгаанд дүн шинжилгээ хийдэггүй. /нийгмийн ажилтан солигдох үед дараагийн ажилтандаа баримт бичгээ албан ёсоор хүлээлгэн өгөөгүйгээс өмнөх оны баримтууд байхгүй/
- Камерын хяналт тогтмол бус, дотуур байрны багшийн журнал хөтлөлт хангалтгүй
- Эрсдэлтэй хүүхдийг холбон зуучлах үйлчилгээ дутмаг
- Зарим сургуулиудын дотуур байрны багш нар туршлага хангалтгүй, дотуур байрны сурагчдад чиглэсэн хүүхэд хамгааллын болон, хөгжлийн төлөвлөгөөг бүрэн боловсруулдаггүй. Дотуур байрны багшийг нийгмийн багш хавсран хийж байгаа алдаа зөрчлүүд илэрсэн.
- Бат-Өлзий сумын 1-р сургуулийн дотуур байр, Политехник коллежийн дотуур байрын барилгууд олон жилийн насжилттай барилгын стандартад нийцээгүй, хүүхэд амьдрах ая тухтай, аюулгүй орчин нөхцөл бүрдээгүй байна.




Бат-Өлзий сумын 1-р сургуулийн дотуур байр

Политехник коллежийн дотуур байр

Өвөрхангай аймгийн хэмжээнд нийт сургуулиудаас авсан санал асуулгын үр дүн

1. Хүүхэд хамгааллын чиглэлээр тулгамдсан, төрийн бодлогын шийдэл хэрэгтэй ямар нэгэн асуудал байна уу?	2. Хүүхэд хамгааллын чиглэлээр 2019-2023 оны тус байгууллагад хийгдсэн ажлуудаас сайн туршлагаа бичнэ үү.
1. Сургууль бүрийг хүүхдийн тооноос үл хамааран эмч, сэтгэл зүйчтэй болгох. 2. Хүүхэд чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх хөгжлийн цогцолбор танхим 3. Удирдлагуудыг хүүхэд хамгааллын чиглэлээр мэдлэгтэй болгох 4. Төрийн албан хаагчид, болон /иргэдийн/ хүүхдэд чанартай цаг гаргадаг байх талаар хуульчилж өгөх /Хүүхэд хамгааллын хуулиас гадна бусад хууль журамд /төрөөс баримталж буй хууль болгонд ямар нэгэн байдлаар хүүхэд хамгааллын талаар заалт оруулдаг байх 5. Анги удирдсан багш нарт ангийн ажлын цаг гаргаж өгөх, эцэг эхчүүд рүү чиглэсэн үр дүнтэй ажил зохион байгуулах жишээ нь: /суманд гэр бүлээрээ хамрагддаг сургалт, ярилцлагыг тогтмол хийх/ Гэр бүлүүдэд хариуцлага, хүүхдээ зөв хүмүүжүүлэх арга ухааныг зааж өгөх нь үр дүн гарна. 6. Төрийн байгууллагын уялдаа холбоог сайжруулах, зөвлөн туслах, мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа зохион байгуулах хяналт шалгалт бус 7. Хүүхэд хамгааллын асуудлыг нэгдүгээрт тавих. Кейс дээр ажиллаж буй нийгмийн ажилтнуудын кейс шийдвэрлэлтийг хянах, урамшуулалтай болгох. 8.Хүүхдийн эрхийг дэндүү дээгүүр тавьснаар хүүхдийн хүмүүжил маш их муудаж байна 9. АУБ-ын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх улам тодорхой болгох. Хүүхэд хамгааллын асуудал ЕБС-ийн орчинд зөвхөн нийгмийн ажилтны үүрэг юм шиг байдаг нь учир дутагдалтай байдаг. 10.Нийгмийн ажилтны хариуцлага их боловч эрх мэдэл дутмаг юм шиг санагддаг. 11. Эцэг, эхийн хараа хяналтыг сайжруулахад төрийн бодлого шийдвэр хэрэгтэй байна. Үр хүүхдээ үл хайхрамж сургууль завсардуулна, сургууль руу дайрч давшлан, багштай хамтарч ажиллахаас цааргалж 70321111-д гомдол гаргадаг. Хүүхдүүдийнхээ хүмүүжилд анхаарахгүй зөрчил гарсан тохиолдолд цагдаа нар ар гэрээс нь заавал насанд хүрсэн асран хамгаалагчийг нь ирүүлдэг байх. Нийгмийн ажилтан, АУБ нарыг дууддаг хэр нь ар гэрийнхэн нь дуудаад ирдэггүй юм гээд байж байдаг нь учир дутагдалтай. 12. Мэргэжлийн сэтгэл зүйч, эцэг эхийн үүрэг хариуцлага, хамтын оролцоо, анги удирдсан багшийн ажиллах чиглэлийг шинэчлэх, тодорхой болгох 13. Дотуур байрын багш нарын цалингийн шатлалыг бусад мэргэжлийн багш нарынхтай ижил түвшинд хүргэх /Шатлал доогуур байгаа нь боловсон хүчин тогтвор суурьшилтай ажиллахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна/. Багш нарын үр дүн урамшуулал тооцоход дотуур байрын багш нарыг багтаах.	1. Багш айлчлал аргачлалаар эрсдэлт нөхцөлд амьдарч буй сурагчдыг илрүүлж судалгааны мөрөөр арга хэмжээ авч ажилладаг. 2. Дотуур байрны хүүхэд болгонтой гурвалсан гэрээ хийснээр хүүхдийн төлөвшилд ахиц гарсан. Дотуур байрны хүүхэд болгоныг гэнэтийн ослын даатгалд хамруулдаг 3. Эцэг эхчүүдтэй уулзалт зохион байгуулах. Нөгөөтээгүүр хүүхдүүдэд өөрсдөд нь эрсдэл гэж юуг хэлээд байгаа, өөрийгөө хэрхэн яаж хамгаалах талаар ярилцах.7 хоногт дор хаяж 2-3 хүүхэдтэй ганцаарчилсан уулзалт хийх нь сурагчдын итгэлийг олох, мөн дотно байх нөхцөлийг бүрдүүлдэг.Эхэн үед хүүхэдтэй ярилцахад асуудлаа нуудаг ичдэг бол 2 Здахь уулзалтаас огт өөр болдог. 4. Урьдчилан сэргийлэх ажлуудаа тогтмол авч хэрэгжүүлж байсан 5. "Хүүхдээ сонсох өдөр"-ийг улирал бүр хийж хэвшсэн. Хүүхдүүдийн гаргаж ирсэн асуудлыг эрэмбэлж шийдвэрлэдэг болсон. "Багш айлчлал" аргачлалаар сурагчдын эрсдэлийн тодорхойлж бууруулж ажиллаж байна. Үе тэнгийн дээрэлхлийг бууруулах ажлыг улирал бүр зохион байгуулж хэвшсэн. ХӨУБ -ын тоог нэмэгдүүлж, сурагчдын оролцоог нэмэгдүүлсэн. Амьдрах ухааны сургалтууд зохион байгуулагдаж байна. 6. Улирал бүр хүүхдээ сонсох өдөр үйл ажиллагааг зохион байгуулж сурагчдад тулгамдаж буй асуудлыг илрүүлсэн, БАА -ын судалгааг жил бүр хийж сурагчдын эрсдэлийн судалгааны сан бүрдсэн, Хүүхэд хамгааллын чиглэлээр "Нандин тойрог" " Анхаарч хамгаалъя" "Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй" зэрэг нөлөөллийн аянуудыг амжилттай зохион байгуулсан 7. Эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийт, багш нарт сургалт, нөлөөллийн ажлууд 8. Өсвөр насныхан, залуучууд, иргэд, багш нарыг хамруулсан хэлэлцүүлгүүд 9. Ажилтан, албан хаагчдын Хүүхдийн өрөө байгуулж, үйл ажиллагаа тогтмолжсон. 10. Байгууллагуудын дэргэдэх Эцэг эхийн зөвлөлүүд байгуулагдаж, үйл ажиллагаа тогтмолжсон.



3.2.3 Эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлж байгаа ч эмч нарыг хүүхэд хамгаалалтай холбоотой арга зүйгээр хангах, хуульд заасан тодорхой үүргийг таниулж ойлгуулах талаар мэдээллийг тогтмол хүргэх шаардлагатай байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1⁹, 7.2¹⁰, 7.3¹¹-д “Эрүүл мэндийн үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал”-ын талаар заасан бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/240 дүгээр тушаалаар “Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын журам”-г баталсан.

Аймгийн Эрүүл мэндийн газраас МУЗГ-ын 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтоолоор баталсан Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бусад салбарын оролцоотойгоор бэхжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилго бүхий “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд дараах ажлууд 2019-2023 онд хийгдсэн байна. Үүнд:

Хийгдсэн ажил /зорилго, үр дүн/, хамрагдсан оролцогчид	
“Аюулгүй бай-Эрүүл бай” сэдэвт аян	Цэцэрлэг, сургуулийн орчны эрсдэлийг үнэлсэн, ахуйн осол гэмтлийн талаар 1329 эцэг эхчүүдэд зөвлөмж өгсөн
Аймгийн нийт 18 сум, 3 өрхийн ЭМТ-үүдийн дунд “МИНИЙ ГЭР - АЮУЛГҮЙ ОРЧИН” 1 сарын аян	Бага насны хүүхдийн ахуйн осол гэмтэл, өвчлөл, нас баралтыг бууруулах зорилгоор зохион байгуулсан.
ЕБС-ийн сурагчдаас үе тэнгийн сургагч бэлтгэх сургалтыг аймгийн БСУГ, МГБССН-тэй хамтран “Нэг ангид нэг зөвлөгч” сэдэв дор зохион байгуулж	Арвайхээр сумын ерөнхий боловсролын 5 сургуулийн 9-11 дүгээр ангийн 55 сурагчийг хамруулж, үе тэнгийн сургагчаар бэлтгэсэн.
0-18 насны хүүхдийн өвчлөлийн байдалд судалгаа хийж, аймгийн хүүхдийн төлөө зөвлөлд танилцуулан, бусад байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах, уулзалт хэлэлцүүлгийн зохион байгуулсан	Бага насны хүүхдийн автын осол гэмтэл гараагүй, мөн нийт осол гэмтэл буурсан үзүүлэлттэй байна.
ДЭМБ, ГССҮТ-тэй хамтран “Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа болон өртөж болзошгүй хүүхдийг эрт илрүүлэх, мэдээлэх” тухай сургалт	Арвайхээр сумын ЕБС-ийн бүх багш, ажилчид нийт 525 хүнийг хамруулсан
Аймгийн ГБХЗХГ-ын дэргэдэх өсвөр үеийн кабинет, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, халдварт ба халдварт бус өвчин, БЗДХ-аас сэргийлэх сургалт сурталчилгааг явуулсан.	11000 гаруй өсвөр үеийнхэнд мэдээлэл хүргэсэн
Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд “Өсвөр үеийн кабинет”-ыг НҮБХАС-ийн дэмжлэгтэйгээр байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн.	
Өсвөр үеийнхний жирэмслэлт, төрөлт, үр хөндөлтийн талаарх 3 жилийн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, хүчирхийллийн эсрэг зөвлөлдөх уулзалтад оролцсон	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газар, Боловсрол, соёл урлагийн газар зэрэг байгууллагын төлөөлөлд танилцуулж, хамтарсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна

⁹ Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчид заавал мэдээлнэ.

¹⁰ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан тушаалтан, хувь хүнд мэдээлэхийг хориглох бөгөөд задруулснаас үүдэн гарах үр дагаврыг өөрөө хариуцна.

¹¹ Эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлнэ.

Хүүхэд хамгаалал, бага болон өсвөр насны хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, зөв дадал төлөвшүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах 3 чиглэл бүхий “Санамж бичиг”-ийг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газартай байгуулж, хамтран хэрэгжүүллээ. Санамж бичигт тусгагдсан чиглэлийн дагуу 58 хүүхдийг үе тэнгийн сургагчаар бэлтгэсэн	Эрт илрүүлгийн үзлэгт 17917 сургуулийн насны хүүхдийг хамруулсан нь нийт үзлэгт хамрагдсан иргэдийн 58.7 хувийг эзэлж, 6-17 насны үзлэг нь илрүүлгийг тэргүүлж байна.
Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын суралцагч хүүхдүүдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах ажлын хүрээнд Арвайхээр сумын 13-р цэцэрлэгт Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “ Бяцхан эмч ” клубыг байгуулсан	Ахлах болон бэлтгэл бүлгийн 10 хүүхдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн.
Цэргийн насны залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг Насан туршийн суралцахуйн нэгжтэй хамтран 2022 онд зохион байгуулсан	Насан туршийн суралцахуйн нэгжийн болон эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан нийт 48 мэргэжилтнийг сургагч багшаар бэлтгэж, тэднээр дамжуулан өсвөр, ялангуяа залуучуудад хүргэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан байна.
Сүүлийн жилүүдэд аймгийн хувьд газрын гарц муудсантай холбоотой ган болсон сумуудын айл өрхийн 80 хувь орчим нь бусад аймаг сумдад отор нүүдэл хийсэн. Эдгээр отор нүүдэл хийсэн айл өрхүүдийн судалгааг авч өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл зөвлөгөөгөөр хангах ажлыг тухайн аймаг, сумын Засаг Дарга, сумдын эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулж, нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчлэн ажилласан байна.	Жирэмсэн эх 7 сумын 800 гаруй өрхийн 2300 гаруй иргэн, түүний дотор 53 жирэмсэн, 0-5 насны 530 гаруй хүүхдэд явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн

Өвөрхангай аймгийн хэмжээнд 2019-2023 онд бүртгэгдсэн өсвөр насны хүүхдүүдийн үр хөндөлт, өвчлөлийн тоон мэдээлэл:

Хүснэгт-17 Өсвөр насны хүүхдүүдийн өвчлөлтэй холбоотой зарим үзүүлэлтүүд

№	Огноо	ӨСВӨР НАСНЫ ХҮҮХЭД /10-19 нас/		
		Үр хөндөлтийн тоо	Бэлгийн замын халдварт өвчний тоо	Амиа хорлолтын тоо
1	2019	14	47	0
2	2020	18	48	2
3	2021	22	22	3
4	2022	22	47	2
5	2023	9	22	1


Эх сурвалж: Аймгийн Эрүүл мэндийн газрын статистик мэдээлэл

Дээрх үзүүлэлтээс харахад өсвөр насны хүүхдүүдийн үр хөндөлт 2019-2021 онуудад өсөлттэй, 2023 онд бууралттай; бэлгийн замын халдварт өвчний өвчлөл 2022 онд өсөн 2023 онд буурсан үзүүлэлттэй байна.

Өсвөр үеийнхний жирэмслэлт, төрөлт, үр хөндөлтийн жилийн эцсийн тоон мэдээлэлд тухай бүр дүн шинжилгээ хийж, тодорхой арга хэмжээнүүдийг салбар дундын оролцоотойгоор авч хэрэгжүүлснээр 20-оос доош насны үр хөндөлт буурах хандлагатай болж, улсын дунджаас 0.5 хувиар өндөр, аймгуудын дунджаас 0.7 хувиар доогуур үзүүлэлттэй байна.

Өвөрхангай аймгийн хөдөөгийн 18 сум, Арвайхээр сумын 4 өрхийн эрүүл мэндийн төв бүгд нийгмийн Эрүүл мэндийн ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймгийн Эрүүл мэндийн газраас үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн хүрээнд



урьдчилан сэргийлэх, эрсдэл бууруулах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2019-2023 онд тодорхой ажлууд хийгдсэн байна. Харин сумдын эрүүл мэндийн төвүүдийн хувьд сумын нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулсан ажлууд хомс, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Хамтарсан багуудтай хийсэн уулзалт ярилцлага, холбогдох бичиг баримтаас үзэхэд эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлж байна.

Харин эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагад мэдээлсэн талаар мэдээлэл хомс байна.

Сумдын эмнэлгүүд дээр эмч, ажилчид солигдон ажиллах тохиолдол их байдаг тул эмч нарт хүүхэд хамгаалалтай холбоотой арга зүйгээр хангах, хуульд заасан тодорхой үүргийг таниулж ойлгуулах талаар мэдээллийг тогтмол хүргэх шаардлагатай байна.

3.2.4 Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны салбарт хүүхэд хамгааллын нэгдсэн бодлого байхгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8¹² дугаар зүйлд “Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал”-ын тухай эцэг эх, иргэний үүрэг, хариуцлага, Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллагын хяналт тавьж ажиллах тухай заалтуудыг тусгасан байна.

Аймгийн хэмжээнд 2019-2023 онд 108 утасны дуудлагаар хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалалтай холбоотой дуудлага 5 ирж, шийдвэрлэгдсэн байна.

Цахим орчинд хүүхэд хохирсон гэмт хэргийн тоо 2019 онд 1, 2020 онд 2, 2021 онд бүртгэгдээгүй, 2022 онд 1, 2023 онд 2 бүртгэгдсэн байна.

Аудитаар талбар дээр ЕБС-үүдэд ажиллах явцад нийгмийн ажилтнууд сурагчдаас авч буй санал асуулга, хүүхдүүдээс ирж буй зөрчлийн мэдээллүүдээс цахим орчинтой холбоотой хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдлууд тодорхой хэмжээнд бүртгэгдсэн байх бөгөөд сургуулийн орчинд тус асуудлуудыг шийдвэрлэж явж байгаа нь ажиглагдсан.

Хүүхдийг цахим орчинд хамгаалъя үйл ажиллагаа, цахим хэрэглээний талаар журамлаж, хяналт тавих үйл ажиллагаанууд боловсролын орчинд хийгдэж ирсэн байна. Зөвхөн сургууль, багш бус эцэг эх, иргэний үүрэг, хариуцлага, хяналт хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчинд маш чухал юм. Иймээс энэ тал дээр эцэг эх, асран хамгаалагч нарт чиглэсэн үйл ажиллагааг мөн түлхүү явуулах, нэгдсэн бодлогоор хангах шаардлагатай байна.

¹² 8.1.Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом ном, урлагийн бүтээл, мэдээ, мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаална.


8.2.Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, ном, урлагийн бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.

8.3.Хүүхдэд зориулсан мэдээ, мэдээлэл нь хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй гэж үзсэн иргэн, хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч, хүүхдийн эрхийн ажилтан энэ тухай гомдол, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хандан шийдвэрлүүлнэ.

8.4.Сонин хэвлэл, телевиз, радио, цахим сүлжээ ашиглаж, хүүхдийн хувийн нууцад халдаж дуу, дуу-дүрсний, дүрсний бичвэр, гэрэл зураг тараасан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж мэдээлсэн, олны өмнө гутаасан ажилтан, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

8.5.Арван зургаан насанд хүрээгүй хүүхэд бусад хүүхдийнхээ эсрэг хийсэн энэ зүйлийн 8.4-т заасан үйлдлээс үүсэх хохирол, хор уршгийг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуульд заасны дагуу хариуцна.

8.6.Интернэтийн орчинд эрх эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээд хүүхдэд зориулсан тусгай багцын үйлчилгээтэй байх бөгөөд үйлчилгээний гэрээ байгуулахдаа тухайн этгээдийн асран хамгаалалд 18 нас хүрээгүй хүүхэд байгаа эсэхийг заавал асууж, насанд хүрэгчдэд зориулсан тусгай сувгийн үйлчилгээг хэрэглэх эсэхийг тохиролцоно.



3.2.5 Олон нийтийн арга хэмжээ, Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4-д “Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал”-ын талаар худалдаа үйлчилгээ, жагсаал цуглаан, замын хөдөлгөөн, уралдаан тэмцээний үе дэх хүүхдийг эрсдэлд оруулахаас урьдчилан сэргийлэх; хүүхдийн эрхийг зөрчсөн тохиолдлыг заавал мэдээлэх ГХ-ээс урьдчилан сэргийлэх тухай заасан.

Соёлын сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/424 дүгээр тушаалаар “Соёлын салбарын хүүхэд хамгааллын бодлого”, “Соёлын салбарын албан хаагчийн хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм”-г тус тус баталсан. Соёлын салбарын хүүхэд хамгааллын бодлогод соёлын салбарын бүх шатны байгууллага Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын жишиг бодлого, Эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмжийг мөрдөж ажиллана гэж заасан. Тус бодлогын баримт бичиг соёлын салбарт хэрэгжиж эхлээгүй байна.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ дэх хүүхэд хамгаалалтай холбоотой дуудлага 2019-2023 оны байдлаар:

Хүснэгт-18 Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагын тоо /ОНАХ/

№	108 дуудлагын /орчны төрөл/	2019	2020	2021	2022	2023
1	Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал	1	0	5	5	7

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээлэл

Дээрх тоон үзүүлэлтээс харахад энэ төрлийн дуудлага сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна.

Олон нийтийн арга хэмжээ, Соёл, спортын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, байгууллагуудад мэдээлэл хүргэх тал дээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай байна.

3.2.6 Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгааллын талаар зохих арга хэмжээг авч ажиллажээ.


Онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгаалалд “Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага” MNS 6948: 2021 стандартыг мөрдлөг болгон ажилласан байна.

Жил бүр хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2019-2023 онд дараах аянуудыг Онцгой байдлын газраас зарлаж, хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

- “Хүүхэд хамгаалал бидний оролцоо”
- “Хамтдаа шалгая хамгаалъя”
- “Анхаарч хамгаалъя”
- “Үер уснаас үрсээ хамгаалъя”
- “Хичээл эхэллээ”
- “Хүүхдийн аюулгүй байдал-таны хариуцлагаас”
- “Бүү гатал-болгоомж илүүдэхгүй” аянуудыг өрнүүлж ажилласан.
- “Өсвөрийн аврагч” тэмцээнийг жил бүр тогтмол зохион байгуулж ажилласан байна. Тухайлбал:

Гал түймэр, гамшиг ослоос өөрийгөө хамгаалах, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах танхим болон дадлага 150 гаруй сургалтад сургууль, цэцэрлэгүүдийн 5000 орчим сурагчдыг хамруулсан байна.

Онцгой байдлын газрын үйл ажиллагаатай танилцах, аюулгүй амьдрах ухаанд сургах зорилгоор Арвайхээр, Нарийнтээл, Хайрхандулаан, Хужирт сумын ерөнхий



боловсролын сургуулийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүдийг Гал түймэр унтраах, аврах ангитай танилцуулах, танхимын сургалтад хамруулах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж 12 сургуулийн 16 бүлгийн 400 гаруй сурагчид, 10 цэцэрлэгийн 12 бүлгийн хүүхдүүдийг хамруулсан байна.

Өвөрхангай аймгийн хүүхэд хамгааллын баг болох Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газар, аймгийн Цагдаагийн газартай хамтран 2021, 2022, 2023 оны өвлийн улиралд хүүхдийг гэмтэл ослоос урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдийн хараа хяналтыг сайжруулах зорилгоор баяр амралтын өдрүүдэд гэр хорооллын гудамж, талбайгаар шуурхай албаны чанга яригчтай автомашинаар сэрэмжлүүлэг өгч мөн агаарт гарч Онги, Дэлгэрэх голын мөсөн дээр гулгаж байгаа иргэдэд гэр бүлийн гишүүдээ автомашины араас зориулалтын бус хэрэгсэл дээр суулгаж чирэхгүй байх, хүүхэд залуучуудад мөсөн дээр аюулгүй тоглож наадах, болзошгүй аюул, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар сэрэмжлүүлэг зөвлөмжийг өгч үүсэж болзошгүй эрсдэлийг таслан зогсоосон байна.

Мөн нийтийн эзэмшлийн гудамж талбайд хяналт хийж нийт 79 эрсдэлтэй орчныг тогтоон эрсдэлийг 57 хувиар бууруулан ажилласан байна. Тус арга хэмжээнд нийт 2800 гаруй иргэд хамрагдаж, цахимаар 67.800 гаруй иргэдийн хандалт авсан байна.

Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газраас сүүлийн 5 жилд хүүхдүүдэд чиглэж хийсэн ухуулга сурталчилгаа, сургалтад хамрагдсан хүүхдийн /0-18 насны/ судалгааг харуулбал:

Хүснэгт-19 Аймгийн Онцгой байдлын газраас хийсэн ухуулга сурталчилгаа, сургалтад хамрагдсан хүүхдийн тоо

№	Он	Объектын түймэр	Үер усны осол	Аянга, цахилгаан	Салхи шуурга	Халдварт өвчин	Газар хөдлөлт	Химийн хортой бодис	Ахуйн осол	Ган, зуд	Нийт дүн
1	2019	2412	2412	1530	2412	1530	2412	1530	2412	1530	20199
2	2020	2845	2845	2152	2845	2152	2845	2152	2845	2152	24853
3	2021	3158	3158	2568	3158	2568	3158	2568	3158	2568	28083
4	2022	4957	4957	3157	4957	3157	4957	3157	4957	3157	39435
5	2023	3745	3745	2895	3745	2895	3745	2895	3745	2895	32328
	Нийт	17117	17117	12302	17117	12302	17117	12302	17117	12302	134793

Эх сурвалж: Аймгийн ОБГ-ын статистик мэдээлэл


Хүснэгт-20 Аймгийн хэмжээнд 2019-2023 онд гал түймэр, аюулт үзэгдлийн улмаас нас барсан хүүхэд

№	Он	Объектын түймэр	Усны осол	Тээврийн хэрэгслийн осол	нийт
1	2019	-	2	-	9
2	2020	-	-	-	
3	2021	1	1	-	
4	2022	-	-	2	
5	2023	-	3	-	
	Нийт дүн	1	6	2	

Эх сурвалж: Аймгийн ОБГ-ын статистик мэдээлэл

Аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан Гамшиг онцгой байдлын үеийн бэлэн байдлын бэлтгэл сургуулилтад аймгийн ХГБХХГ-ийн “Нийгмийн хамгааллын мэргэжлийн анги”, “Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги” бүрэлдэхүүний 23 албан хаагчийг бүрэн хамруулж, онцгой байдлын үеийн бэлтгэл бэлэн байдлын үзүүлэлтийг ханган оролцсон. Мөн “Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын арга зүй” сургалтад 4 албан хаагч хамрагдаж, мэдлэг, мэдээлэл авсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Онцгой байдлын Ерөнхий газар, Монголын Улаан загалмайн нийгэмлэг, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан, Өмнөговь аймгийн



Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Онцгой байдлын газар хамтран “Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал” арга зүйн зааварчилгаа өгөх говийн бүсийн бэлтгэл сургуулилтад аймгийн хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн 6 гишүүн хамрагдаж, чиг үүргийн дагуу чадавхажсан.

Covid-19 цар тахлын үед ХГБХХГ-с эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн судалгааг нарийвчлан гаргаж шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажилласан байна. Үүнд:

- Аймгийн 19 суманд эрсдэлтэй өрхийг илрүүлэх түргэвчилсэн үнэлгээ хийж одоогийн байдлаар 281 өрхийн мэдээллийг программд оруулсан байна. Тус үнэлгээг хийх явцдаа үйлчилгээ зайлшгүй үзүүлэх шаардлагатай 86 өрхөд наад захын хэрэгцээг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүнсний тусламж, ариутгалын бодис, витамин зэрэг зүйлээр дэмжлэг үзүүлэх ажлыг Арвайхээр, Хархорин, Баян-Өндөр зэрэг сумдад зохион байгуулсан байна.
- Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн судалгааг гаргах зорилгоор Арвайхээр сумын хамтарсан багийн гишүүдтэй хамтран нөхцөл байдлын үнэлгээг хийж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор дээрх үнэлгээнд хамрагдсан өрхүүдэд шаардлагатай хариу үйлчилгээг хүргэн, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дээрх өрхүүдэд зөвлөмж, гарын авлага, сурталчилгааны материалыг нийт 2000 орчим иргэнд мэдээлсэн.
- Амьжиргааны баталгаажих түшингээс доогуур орлоготой, хүнсний эрхийн бичигт хамрагдаагүй өрх толгойлсон эцэг, хүү хоёрт, гурил, будаа, цай зэрэг наад захын хэрэгцээний хүнсний дэмжлэг үзүүлж ажилласан. Дээрх үйл ажиллагаанд насанд хүрсэн 149 иргэн, 192 хүүхэд хамрагдаж, урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлсэн байна.
- Эрүүл мэнд, Боловсрол, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, хамтарсан багт мэдээллийг хүргүүлэн үйлчилгээнд холбон зуучилж ажилласан байна.

“Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам”-ын хэрэгжилтийн хүрээнд Гамшиг, онцгой байдлын үед хамтран ажиллах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудтай хамтран үер, усны ослоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, үерийн аманд зусаж байгаа 50 өрхөд нүүх санамж өгч, 11 айлыг албадан нүүлгэж, эрсдэлд өртсөн 4 өрхөд сум орон нутгийн ЗДТГ-тай хамтран 10 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 2 өрхөд гэр олгосон байна.

Ган, зуд тохилолдсон 2022-2023 оны хувьд аймгийн малчин өрхүүдээс 15 сумын 726 өрхийн 2032 иргэн, үүнээс цэцэрлэгийн насны 252, сургуулийн насны 409 нийт 661 хүүхэд нийслэлийн 2 дүүрэг, 14 аймгийн 80 суманд нүүн суурьшиж байсан судалгаа гарчээ. Эдгээр хүүхдийн 257 нь айлд сууж, 93 нь дотуур байранд амьдарч байна гэсэн судалгааг гаргаж, судалгааны дагуу эрсдэлийг бууруулах арга хэмжээ зохион байгуулах талаар албан бичгийг сумдын хүүхдийн төлөө зөвлөл болон Хамтарсан багуудад хүргүүлж, Хөдөө аж ахуйн газартай хамтран ажилласан байна.


3.3. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа үр дүнд ахиц гарч байна.

3.3.1 Монгол Улс Хүүхдийн эрхийн олон улсын конвенцод нэгдсэн үүргийн талаар жил бүрийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.9¹³, 15 дугаар зүйлийн 15.1.8¹⁴-д Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагын үүрэг, оролцооны тухай заасан, 21 дүгээр зүйлийн 21.1.1 "Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу Олон Улсын төрөлжсөн байгууллага (Нэгдсэн Үндэсний Байгууллага, түүний салбар байгууллага)-д Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн

¹³ 14.1.9.хүүхдийн эрхийн чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

¹⁴ 15.1.8.хүүхдийн эрхийн чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;



талаар үндсэн тайланг заасан хугацаанд төрийн байгууллагаас хүргүүлэх бөгөөд хүүхэд, олон нийт, иргэний нийгмийн оролцоотой гаргана"-д гэж заасан байна.

Тус байгууллагын Стратеги төлөвлөгөөний зорилго 2.4.3-д “Гэр бүл, хүүхдийн эрх хамгааллын талаарх хууль тогтоомж, бодлого, Олон улсын гэрээ конвенци, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, сурталчлах, хүүхдийн болон эмзэг бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах, нийгмийн бүх орчинд хүүхдийн эсрэг хүчирхийллийг хориглох, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ажлыг үндэсний хэмжээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, хамгааллын үйлчилгээний салбар дундын зохицуулалтыг хийж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, гэр бүл, хүүхдийн эрхийн мэргэжилтэн, нийгмийн ажилтнуудын чадавхыг дэмжих, арга зүйгээр хангах, үйлчилгээний нэр төрөл, чанар, стандартыг сайжруулах.” гэж заасан. Тус зорилгыг жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

3.3.2 Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийгдээгүй, үр дүнгийн мөрөөр арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Хүүхдийн тусламжийн 108 утас нь хүүхдийн эрхийн үндсэн зарчмын дагуу хүүхэд бүр аюулгүй тайван, хүчирхийлэлгүй орчинд амьдрах эрхийг хангах механизмыг бүрдүүлэх зорилго бүхий цогц бодлогын хүрээнд

- Хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах,
- Хүүхдийн санаа бодлыг сонсох,
- Тэдний дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд хүргэх,
- Хүүхдийг хөгжүүлэх,
- Хүүхдийн оролцоог хангахад чиглэсэн үйлчилгээний нэгдэл бий болгох үндсэн зорилготой байгуулагдсан.

Хүүхдийн тусламжийн утас нь 24 цагийн турш үнэ төлбөргүйгээр Монгол улсын өнцөг булан бүрээс 0-18 насны хүүхдийн хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлийн тухай мэдээлэл хүлээн авч, тухайн орон нутаг, байгууллагын мэргэжлийн үйлчилгээнд холбон зуучлах, яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээнд холбон зуучлах, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн мэдээллийг хүргэх, хүүхдийн дуу хоолойг сонсон хүүхэд хамгааллын асуудлаар шийдвэр гаргахад болон хүүхэд хамгаалалд хүүхдийн оролцоог хангах, оролцоонд тулгуурлан хүүхдийг хөгжүүлэх, эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалалд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүүхдийн тусламжийн 108 утсыг хүүхдийн эрхийн зөрчлийг мэдээлэх, зөвлөгөө мэдээлэл авах үндсэн эх сурвалж болж, олон нийт тэр дундаа хүүхдүүдийн дунд танигдсан байна. Дуудлагын бүртгэл мэдээллийг харахад даваа, баасан гаригуудад их давтамжтай байх бөгөөд 20 цагаас хойш дуудлага ихэсдэг байна. Өвөрхангай аймгийн хэмжээнд 2019-2023 оны хооронд Хүүхдийн тусламжийн 108 дугаарт 446 дуудлага, мэдээлэл бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн дуудлага мэдээллийн дагуу аймгийн Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газар, Хамтарсан багууд голлох үүргийг хэрэгжүүлэн ажиллаж иржээ. Тусламжийн утасны дуудлагыг ерөнхий ангиллаар хүүхэд хамгааллын, зөвлөгөө хүссэн гэж ангилдаг. Аймгийн хэмжээнд ирсэн дуудлагын тоог 2019-2023 оны байдлаар харуулбал:

Хүснэгт-21 Аймгийн хэмжээнд 108 утсанд ирсэн дуудлагын тоо

№	Он	Хүүхэд хамгаалал	Зөвлөгөө хүссэн	Нийт
1	2019	35	18	53
2	2020	50	6	56
3	2021	84	10	94
4	2022	94	21	115
5	2023	112	16	128

Нийт дүн	375	71	446
-----------------	------------	-----------	------------

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээлэл

Дээрх хүснэгтээс харахад 5 жилийн нийт дуудлагын 84.08%-г хүүхэд хамгааллын чиглэлийн дуудлага эзэлж байгаа бөгөөд энэ төрлийн дуудлагын тоо жилээс жилд өссөн байна. Нийт дуудлагаас 2021 оны 1, 2022 оны 19, 2023 оны 18 дуудлага хаагдаагүй, ажиллаж байгаа төлөвтэй байна.

Хүүхдийн тусламжийн удирдлагын системд бүртгэгдсэн дуудлага, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаа нь ихэнхдээ 1-2 сарын хугацаатай үргэлжилжээ. Аудитын явцад түүврээр 49 дуудлага, мэдээллийг шалгахад 5 дуудлага он дамжиж шийдвэрлэгдсэн байна. Тусламжийн утсанд ирүүлсэн дуудлагын төрлөөс шалтгаалан шаардлагатай арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлсэн байна. Уг удирдлагын системд 2022 оноос дуудлагын үнэлгээ, үзүүлсэн үйлчилгээ, холбогдох нотлох баримтуудыг бүрэн байршуулж ирсэн байна. Өмнөх онуудад системийн хөгжүүлэлттэй холбоотой зарим дуудлагын бүрдэл хангалтгүй байна.

Тусламжийн утсанд бүртгэгдсэн дуудлагыг ангилахад үл хайхрах хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, сэтгэл санааны хүчирхийлэлтэй холбоотой дуудлага зонхилж байна. Үүнд:

- Бие махбодын хүчирхийлэл - 111
- Сэтгэл санааны хүчирхийлэл - 106
- Үл хайхрах - 88
- Эцэг эх байх үүргээ биелүүлээгүй - 80

Дуудлага, мэдээллийг өгч байгаа субъектууд нь голчлон хүүхэд өөрөө байна. Дуудлага мэдээлэл өгөгчийн тайлангаас хамгийн их, бага дуудлага өгсөн төрлүүдийг тоогоор харуулбал:

ХАМГИЙН ОЛОН	ХАМГИЙН БАГА
■ Хүүхэд өөрөө – 104 ■ Бусад иргэнээс – 89 ■ Аав – 83 ■ Ээж – 72	■ Эрүүл мэндийн байгууллага / ГССҮТ, ЭХЭМҮТ/- 4 ■ Боловсролын байгууллага - 4 ■ Хорооны нийгмийн ажилтан - 1 ■ Цагдаа - 1

Дуудлага өгөгчийн төрлөөс харахад хүүхэд хамгаалалд хамгийн гол үүрэг оролцоо бүхий байгууллагуудаас хамгийн бага дуудлага ирсэн байна. Харин энэ талаар аймгийн ХГБХХГ-с ирсэн дуудлагад нарийн дүн шинжилгээг хийж холбогдох салбарууд руу энэ чиглэлээр хамтран ажилласан тайлан мэдээ байхгүй байна.

Зөвхөн гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой дуудлагыг хүлээн авдаг гэхээс илүүтэйгээр зөвлөгөө авах боломжтой гэдгийг сурталчлан таниулах шаардлагатай байна.

3.3.3 Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээнүүдийг авч ирсэн байна.

Сургуулийн нийгмийн ажилтнууд эрсдэлт нөхцөлд байгаа сурагчдын “гэрээр айлчилж нөхцөл байдлын үнэлгээ” хийж ажиллаж хэвшсэн байна. Тухайлбал: Арвайхээр сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн нийгмийн ажилтан маш сайн ажилласан байна.

Сургуулиуд улирал тутам багш айлчлалын үр дүнд гарсан “Эрсдэлийн судалгаа”-г гарган дүгнэлтийг үндэслэн анги удирдсан багш нар эцэг, эхчүүдтэй хамтран ажиллах ажил зохион байгуулж иржээ. Судалгааны үр дүнд тухайн хичээлийн жилийн нийт эрсдэлийн үнэлгээ хийсэн сурагчдын тоо, эрсдэлгүй, бага эрсдэлтэй, дунд эрсдэлтэй, өндөр эрсдэлтэй хүүхдийн тоог гарган хамтарч ажилласан байна.

Хүснэгт-22 Аймгийн хэмжээний нийт хүүхдийн тоог эрсдэлт нөхцөлд орсон хүүхдийн тоонд харьцуулсан байдал

Он	2019	2020	2021	2022	2023
Нийт хүүхдийн тоо	43630	43218	44007	44317	44391

Эрсдэлт бүлэгт байгаа хүүхдийн тоо	736	520	665	498	667
------------------------------------	-----	-----	-----	-----	-----

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээлэл

Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд зориулан сургуулиуд олон арга хэмжээ зохион байгуулж ажилласан байна. Тухайлбал: Арвайхээр сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн орчинд, хүүхэд хамгааллын эрсдэлийн үнэлгээ хийх удирдамж боловсруулан сургуулийн захирлаар батлуулж 2021 оноос эхлэн хүүхдийн орчны эрсдэлийг тодорхойлж ажилласан байна. Жишээлбэл: “Үе тэнгийн дээрэлхэгчийг тэг болгоё” уриатай сургалтыг нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулсан нь үр дүнтэй ажил болсон байна.

Өвөрхангай аймгийн хувьд 2021-2023 онд:

- Эрсдэлийн даатгалд даатгуулсан 1332 хүүхэд нөхөн төлбөр 22.3 сая төгрөг авсан байна.
- Эрүүл мэндийн үйлчилгээнд 269 хүүхэд хамруулсан.
- Сэтгэлзүйн зөвлөгөө 378 хүүхдэд өгсөн байна.
- Нийт 38 шүүх хуралд хууль ёсны төлөөлөгчөөр оролцож, хүүхдийн эрх ашгийг хамгаалсан байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар 19 суманд нийт 32 сургууль, 49 цэцэрлэг, 1 коллеж үйл ажиллагаа явуулж, ЕБС-ийн 34 дотуур байранд 2135 хүүхэд, коллежийн 1 дотуур байранд 104 хүүхэд амьдарч байна.

Ээж аав асран хамгаалагчаасаа хол дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүдийн хувьд дотуур байрын багш гол үүрэг гүйцэтгэж өдөр тутам хүүхэдтэй ажиллах тэднийг эрсдэлээс хамгаалах гол үүрэг гүйцэтгэх хүн байдаг. Гэвч сумдын дотуур байрны багш нар дотуур байрын багшийн журнал хөтлөлт хангалтгүй байна. Тухайлбал: Хужирт, Хархорин, Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан сумдын сургуулиуд

Зүүнбаян-улаан сумын дотуур байранд 2022 онд хүүхдийн амь эрсэдсэн хэрэг гарч байсан боловч одоо дотуур байрын багш байхгүй сургуулийн нийгмийн ажилтанд хавсруулан ажиллаж байгаа нь тун хариуцлагагүй байна.


Мөн Политехник коллежийн дотуур байрны 2 багш мэргэжлийн бус хүн ажиллаж байна.

Өвөрхангай аймагт 2019-2023 онд үйл ажиллагаа явуулж буй дотуур байрны мэдээлэл:

Дотуур байрын орчин, үйлчилгээний ерөнхий стандарт /MNS 6781:2019/-ын 7 дугаар зүйлийн 7.3-д дотуур байрын 50 хүртэлх хүүхэд тутамд нэг багш ногдоно /51-100 хүүхдэд 2 багш, 101-150 хүүхдэд 3 багш, 151-200 хүүхэдтэй бол 4 багш ногдохоор тооцно./ гэж заасан боловч дараах дотуур байрнуудын багшийн тоо стандартын шаардлагад нийцэхгүй байна. Үүнд:

Хүснэгт-23 Аймгийн хэмжээний нийт дотуур байрны хүүхдийн болон багшийн тооны мэдээлэл

№	Сургуулийн нэр	2023 он		
		Дотуур байрны хүүхдийн тоо	Дотуур байрны багшийн тоо	Стандартын дагуу шаардлагатай багшийн тоо
1	Бат-Өлзий сумын ЕБ 1 дүгээр сургууль	142	2	3
2	Баян-Өндөр сумын ЕБС	247	3	4-с дээш
3	Бүрд сумын ЕБС	68	1	2
4	Есөнзүйл сумын ЕБС	75	1	2
5	Зүүнбаян-Улаан сумын ЕБС	84	1	2
6	Өлзийт ЕБС	87	1	2
7	Сант сумын ЕБС	186	2	4
8	Тарагт сумын ЕБС	66	1	2
9	Төгрөг сумын ЕБС	88	1	2



10	Уянга сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	116	2	3
11	Уянга сумын Жаргалант ЕБС	110	2	3
12	Хархорин сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	173	2	4
13	Хужирт сумын ЕБС	128	2	3

Эх сурвалж: Аймгийн Боловсролын газрын статистик мэдээлэл

Дээрх судалгаанаас харахад дотуур байрын багш маш их дутагдалтай байна.

Мөн эрсдэл өндөртэй орчин болох дотуур байрны хувьд багш нарын чадавх дутмаг, сургуулиас дотуур байрны багшид тавих хяналт хангалтгүй байна.

Сургуулийн сэтгэл зүйч сурагчидтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс харахад өсвөр насныхны амиа хорлох бодол тээсэн тохиолдлууд нэлээдгүй илэрсэн байна. Иймд өсвөр насныханд ээлтэй, чанартай сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг сургуулийн орчинд нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хархорин, Арвайхээр, Хужирт, Бат-Өлзий сумдын сургуулиуд орон тооны сэтгэл зүйчтэй ажиллаж байгаа нь сайшаалтай байна.


Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээ үзүүлэхэд хамтарсан багийн үүрэг хариуцлага их чухал байдаг. Сумын хамтарсан багийн ахлагч нь Засаг дарга байгаа нь 4 жилийн бүрэн эрхийн хугацаа дуусаад, хугацаанаасаа өмнө солигддог тул учир дутагдалтай байна. Тухайлбал: Хужирт сумын Засаг дарга солигдсон боловч хамтарсан багийн бүрэлдэхүүн нь хуучнаараа явж байна. Хамтарсан багийн гишүүдийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгцээтэй унаа, уулзалтын өрөө байхгүй, шаардлагатай хөрөнгө мөнгө дутагдалтайн улмаас үр дүнтэй хариу арга хэмжээ, үйлчилгээг үзүүлж чаддаггүй эсхүл заасан хугацаанд үйлчилгээг хүргэж чадахгүй байдал үүссэн байна.

Аймгийн хэмжээнд нийт 36 хамтарсан баг 156 гишүүнтэй хүүхэд гэр бүлд хариу арга хэмжээг авч ажиллаж байна. Хамтарсан багийн тоо сумдад харилцан адилгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-24 Аймгийн хэмжээний нийт хамтарсан багийн мэдээлэл

№	Сумын нэр	Хүн амын нийт тоо	Үүнээс хүүхдийн тоо	Хамтарсан багийн тоо	Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн тоо
1	Арвайхээр	36782	13209	14	2
2	Хархорин	11908	4294	4	2
3	Уянга	9247	3567	2	2
4	Бат-өлзий	7580	2856	1	1
5	Хужирт	6568	2506	1	1
6	Богд	5409	2294	1	1
7	Зүүнбаян-Улаан	3591	1309	1	1
8	Баянгол	3506	1392	1	1
9	Хайрхандулаан	3364	1178	1	1
10	Баян-Өндөр	3351	1307	1	1
11	Нарийнтээл	3348	1263	1	1
12	Сант	3242	1232	1	1
13	Тарагт	3099	1106	1	1
14	Бүрд	2736	1071	1	1
15	Есөнзүйл	2610	1014	1	1
16	Төгрөг	2525	960	1	1
17	Баруунбаян-Улаан	2496	1044	1	1
18	Өлзийт	2156	805	1	1
19	Гучин-Ус	2057	744	1	1
Нийт дүн		115575	43151	36	22

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын судалгаа



Дээрх хүснэгтээс харахад 744 хүүхэдтэй суманд нэг хамтарсан баг ажиллаж байхад хоёр мянгаас дээш тооны хүүхэдтэй Бат-өлзий, Хужирт, Богд сумуудад мөн 1 хамтарсан баг ажиллаж байгаа нь харьцангуй үзүүлэлт юм. Иймээс хүн ам, хүүхдийн тоо их, зөрчил, дуудлага ихтэй зарим сумдад хамтарсан багийн тоог нэмэх шаардлагатай байна. Хамтарсан багуудын хувьд хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд чухал үүрэг оролцоотой ажиллаж буй анхан шатны нэгж юм.Цаашид сумын хүн амын тоог харгалзан хамтарсан багийг нэмж бий болгосноор эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлж байгаа хамгааллын үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэх болно.

Сум, багийн түвшинд ажилладаг хамтарсан багийн үйлчилгээнд орон нутгийн төсвөөс мөнгө хуваарилдаг, хүүхэд хамгааллын төсөвтэй газар байхгүй байна.

Аймаг, сумдын засаг дарга нар хүүхэд хамгаалалд мөнгө зарцуулах нь тэдний нэн тэргүүнд хийх ёстой зүйл гэж боддоггүй учраас хамтарсан баг нь хязгаарлагдмал нөөцтэй, санхүүжилтгүй, улмаар хамтарсан багийн үйлчилгээг төлөвлөж, төсөв тавьдаггүй байна.

Харин улсын төсвөөс хамтарсан багт өгсөн санхүүжилтийг 5 жилээр харуулбал:

Хүснэгт-25 Хамтарсан багт өгсөн 5 жилийн санхүүжилтийн мэдээлэл

Он	Санхүүжилт авсан хамтарсан багийн тоо	Мөнгөн дүн
2019	4	2,000,000
2020	36	20,700,000
2021	19	9,500,000
2022	36	15,900,000
2023	36	15,290,000

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын санхүүгийн мэдээлэл

Дээрх хүснэгтээс харахад нийт 36 хамтарсан баг жилд 9.5-20.7 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Хүүхэд хамгааллын тогтолцоонд мэдээллийн удирдлагын нэгдсэн систем байхгүйгээс хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх мэдээллийг цаг тухайд нь үйлчилгээ үзүүлэгч бусад талтай шуурхай ажиллах, кейсийн үр дүнг үнэлэх, дараагийн үйлчилгээг оновчтой төлөвлөх, үйлчилгээний үр дүнг үнэлэхэд хүндрэл учирсаар байна.


Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь нийт 43 хүүхдэд үйлчилгээ үзүүлснээс хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 6 хүүхэд, хохирогч 24, гэмт хэргийн сэжигтэн 6, гэрч 5 хүүхдэд үйлчилгээ үзүүлэн хууль ёсны төлөөлөгчөөр 37 хүүхдийн эрх ашгийг нь хамгаалан ажилласан байна.

Өвөрхангай аймгийн Хархорин суманд Хүүхэд хөгжил хамгааллын “Солонго” төв нь 2013 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж 3 багш, 1 тогооч, 1 галчтай, 15 хүүхэдтэй ажиллаж байна. Тус төвийн гол зорилго нь Хүүхдийг гэр бүлийн орчинд өсгөн хүмүүжүүлж гэр бүлийн боловсрол олгох, хайр халамжид өсгөн хүмүүжүүлж асран хамгаалах юм.

Тус төвийн орчин нөхцөл сайн боловч гадна, дотор камер байхгүй зэрэг нь эрсдэл үүсэх магадлалтай байна.

3.3.4. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн хэргийн суурь шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан байна.

Аймгийн Цагдаагийн газраас хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн хэргийн үйлдэгдсэн шалтгаант нөхцөлийг судлан үзэхэд архины хамаарал, гэр бүл салалт, эцэг эхийн хайхрамжгүй байдал, төрөл садны хүмүүсийн харилцааны чиг хандлагын зөрүүтэй байдлаас шалтгаалсан байна. Үндэсний болон аймаг, нийслэлийн түвшинд хүүхэд хамгааллын дэд бүтцийн болон санхүүгийн нөөц харьцангуй бэхжиж, төсөв санхүү, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн тоо нэмэгдсэнээр үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, хамтран ажиллах тал дээр ахиц гарсан байна.



Харин, төрийн анхан шатны нэгжийн түвшинд хүүхэд, гэр бүлд хүрч ажиллах, эрсдэлд хүчин зүйлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах хүний нөөц, төсөв санхүү хангалтгүй хэвээр байна.

Шалтгаан нөхцөл байдлыг тодорхойлсноор урьдчилан сэргийлэх ажлыг сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/83 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аюулын зэргийн үнэлгээ хийх журам”-ын дагуу Аюулын зэргийн үнэлгээний тэмдэглэлийг хүнд Кейс бүр дээр бөглөсөн байна.

3.3.5 Зарим салбаруудын хувьд судалгаа, шинжилгээ хийгдээгүй; салбар хоорондын уялдаа хангалтгүйгээс эрсдэл буурахгүй байна.

Хүүхэд хамгааллын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад хүүхэд хамгааллын мэргэшсэн хүний нөөц дутмаг, чадавх сул, хамтын ажиллагаа болон салбар хоорондын зохицуулалт хангалтгүй байгаа нь хүүхдэд үзүүлж байгаа хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.

Энэ нь хүүхэд хамгааллын хуулийг хэрэгжүүлэхэд хамтын ажиллагаа, зохицуулалтыг сайжруулах, оновчтой болгох, стандартчилах шаардлага байгааг харуулж байна.

“Анхаарч хамгаалъя” аяны арга хэмжээнд төрийн байгууллагууд хамтран ажиллаж, хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлж ажиллах, 2021-2024 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж он, оноор нь шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллагыг зааж өгсөн байна.

Гэвч байгууллагууд төлөвлөгөөнд заасан ажилд тухайлан анхаарал хандуулж дорвитой ажил зохион байгуулдаггүй, үндсэн үйл ажиллагаандаа хийдэг ажлыг хөтөлбөрийн заалтад тусган тайлан ирүүлдэг, салбар дундын хамтын ажиллагаа муу, хөтөлбөрт тусгайлан зарцуулах хөрөнгө байхгүй зэрэг дутагдалтай талууд байна.

Аймгийн ХГБХХГ-аас Үндэсний Статистикийн хорооны 2015 оны Хүүхэд хамгааллын 129 үзүүлэлт тооцох аргачлалын дагуу аймгийн Цагдаагийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар зэрэг нийгмийн 7 салбар, сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүд, багийн нийгмийн ажилтнаар дамжуулан анхан шатны нэгжээс статистик тоон судалгааг нэгтгэн, мэдээллийн санг өргөжүүлж, “Статистик-2021”, “Статистик-2022”, Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдлын талаар 2020-2023 оны эмхэтгэлийг боловсруулан гаргасан байна.

Аймгийн Боловсролын газраас 2017 оноос эхлэн ерөнхий боловсролын сургуулийн багш нарын оролцоотойгоор суралцагчдын ар гэрийн орчин нөхцөлд аргачлалын дагуу үнэлгээ хийж, хүүхдийг гэр бүлийн болон үе тэнгийн дээрэлхэл, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллыг бэхжүүлэх, хүүхдийг хөгжил, төлөвшлийг сайжруулж, гэмт хэрэг зөрчилд холбогдох, хохирох явдлыг бууруулах, эдгээр үйл ажиллагаанд эцэг эх асран хамгаалагч, салбар дундын үүрэг оролцоог нэмэгдүүлж, бүтээлч хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилго бүхий “Багш айлчлал” аргачлалыг хэрэгжүүлсэн.

Энэ хүрээнд Өвөрхангай аймгийн хэмжээнд нийт сурагчдын эрсдэлийг тодорхойлох бүрэн боломж үүсэн, мэдээллийн сан бүрэн бүрдсэн байна. Энэхүү мэдээлэлд тулгуурлан хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж буй төрийн байгууллагууд хамтран эрсдэлийг бууруулах тал дээр дүн шинжилгээ хийх бүрэн нөхцөл боломж бүрдсэн байна.

Ийнхүү боловсролын салбараас эрсдэлийг илрүүлэх томоохон мэдээллийн сан үүссэн боловч аймгийн ХГБХХГ нь мэдээллийг бүрэн ашиглаагүй.

Хүүхэд хамгаалалтай холбоотой хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн хүчирхийллийн тоон үзүүлэлт дээр тогтмол дүн шинжилгээ хийж, учир холбогдлыг тогтоогоогүй түүнд чиглэгдсэн хөтөлбөр, арга хэмжээ боловсруулаагүй байна.

Аймгийн Цагдаагийн газар, Боловсролын газраас Хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлтүүдэд дүн хийж ажилласан байна. Харин бусад салбаруудын хувьд судалгаа, шинжилгээ хийгдээгүй, салбар хоорондын уялдаа хангалтгүй байгаа тул эрсдэл буурахгүй байна.



ДЭЭД ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

1. Хүүхэд хамгааллын зардлын санхүүжилтийн нарийн төлөвлөлт, зарцуулалтын зориулалт, ангилал болон ил тод байдалтай холбоотой нарийвчилсан эрх зүйн баримт бичиг боловсруулж ажиллах./хөгжил оролцоо, урьдчилан сэргийлэх зардлыг тусад нь салган журамлах/
2. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлд санхүүжилтийн төлөвлөлт, төлөвлөлтийн үйл явц, зарцуулалтын зориулалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилт зэргийг тусгах. Тухайлбал хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд нийт санхүүжилтийн тодорхой хувийг зарцуулах тухай холбогдох хууль, журамд тусгах;
3. Насанд хүрээгүй хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон хохирогчийн аюулгүй байдалд халдсан, сүрдүүлсэн тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг олон нийтэд таниулан, сурталчлах.
4. Хүүхэд хамгааллын чиглэлээр олгосон санхүүжилт, зарцуулалтад дээд газраас дотоод аудит, хяналт, шалгалтыг 2 жилд 1 удаа хийж байх.
5. Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх салбарын онцлогт нийцсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлал боловсруулж ажиллах.
6. Эцэг, эхийн хараа хяналтыг сайжруулах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх тал дээр төрийн бодлого шийдвэр зайлшгүй хэрэгтэй байна. /хүүхдийн эрх зөрчигдсөн асуудлуудын цаана ихэвчлэн эцэг эхийн хариуцлагын асуудал холбогдон гарч ирж байна./
7. Төрийн болон албаны нууцын тухай хуультай уялдуулан кейсийн хадгалалт, хамгаалалтын талаар журамд нарийвчлан тусгах шаардлагатай байна.
8. Өндөр эрсдэлтэй орчин болох сургуулийн дотуур байрны хүүхэд хамгааллыг сайжруулах үүднээс дотуур байрны багшийн нийгмийн баталгааг сайжруулах чиглэлд бодлогын өөрчлөлт оруулах.
9. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын 1-р сургуулийн дотуур байр, Политехник коллежийн дотуур байрын барилгууд олон жилийн насжилттай барилгын стандартад нийцээгүй, тус байрны хүүхдүүд хүнд нөхцөлд амьдарч байгаа тул ая тухтай, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ГАЗАР

Т.Намнансүрэнгийн 4 дүгээр гудамж, 402, 13 дугаар баг,
Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62166,
Утас: (976) 7032 3355,
Цахим шуудан: uvurkhangai@cfga.gov.mn,
Цахим хуудас: [www.http://uvurkhangai.cfga.gov.mn](http://uvurkhangai.cfga.gov.mn)

2024.10.24 № 01/241
танай -ны № -Т

“ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН”
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР О.БАТЖАРГАЛ ТАНАА

Танай газраас хүүхэд хамгааллын талаар
төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт үр
дүнд хийсэн гүйцэтгэл-нийцлийн аудитын тайлантай
санал нийлж байгаа болно.

ДАРГА Н.ЦЭВЭЭНДУЛАМ

622452478
C.My doc Alban bichig A5 /HGBHHG/



ДҮГНЭЛТ

- Хүүхэд хамгааллын талаар мөрдөж буй хууль тогтоомж, урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан зарим бодлогын баримт бичиг хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.
- Хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан дутмаг, үйл ажиллагаанд хэрэглэгдэж байсан системүүдийн ашиглалт хаагдсанаас шалтгаалан цахим мэдээллийн сан бүрэн үүсээгүй, системийн хөгжүүлэлт хангалтгүй байна.
- Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад дээд газрын шийдвэр олон удаа өөрчлөгдсөнөөс шалтгаалж аймгийн ХГБХХГ-ын бүтэц, орон тооны өөрчлөлт их гарсан байна.
- Аймаг, сумдын хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтнуудын ажлын ачаалал их, нийгмийн баталгаа хангалтгүй /цалин хөлс бага/, эрсдэлт нөхцөлд ажилладаг зэрэг нь хүний нөөцийн тогтвор суурьшилгүй ажиллах гол шалтгаан болж байна.
- Хүүхэд хамгаалалд зориулсан Улсын төсвөөс өгсөн санхүүжилтийг өмнөх онуудын бодит судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна.
- Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх салбарын онцлогт нийцсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлал байхгүй байна.
- Гэр бүлийн орчинд чиглэсэн урьдчилсан сэргийлэх арга хэмжээ хүртээмж муутай байгаагаас шалтгаалан гэр бүлийн орчин дахь хүүхдийн хүчирхийллийн тоон үзүүлэлт буурахгүй байна.
- Боловсролын салбарт эрсдэлийг тодорхойлох сайн жишээ болохуйц “Багш айлчлал” аргачлал хэрэгжиж эхэлснээр суралцагчдын эрсдэлийг тогтмол үнэлж, мэдээллийн бааз бүрдсэн байна.
- Салбар бүрд илэрсэн эрсдэлийн дагуу холбон зуучлах үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.
- Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийгдээгүй, үр дүнгийн мөрөөр арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- Зарим салбаруудын хувьд судалгаа, шинжилгээ хийгдээгүй; салбар хоорондын уялдаа хангалтгүй байгаа тул эрсдэл буурахгүй байна.



ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Т.Нарангарав танаа:

1. Хүүхэд хамгааллын тухай хуульд зааснаар хүүхэд хамгааллын санхүүжилтийг /хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, нэг цэгийн үйлчилгээ г.м/ орон нутгийн төсөвт жил бүр тусгаж батлах;
2. Хүүхэд хамгааллын талаар гарсан хууль тогтоомжийн дагуу ИТХ-аас гарч буй бодлогын баримт бичиг хоорондын уялдаа холбоог хангаж ажиллах.

Аймгийн Засаг дарга бөгөөд аймгийн хүүхдийн төлөө зөвлөлд:

1. Өвөрхангай аймгийн Засаг даргын 2025-2029 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүүхэд хамгааллын талаар тодорхой заалтуудыг тусгаж ажиллах
2. Хүүхэд хамгааллын тухай хуульд зааснаар хүүхэд хамгааллын санхүүжилтийг /хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, нэг цэгийн үйлчилгээ г.м/ орон нутгийн төсөвт жил бүр тусгаж батлуулах;
3. Нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга байгууламжийн асуудлыг шийдвэрлэж, цогц үйлчилгээ үзүүлдэг, нөхцөл боломжоор хангаж ажиллах
4. Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг тогтмол үнэлж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, олон нийтэд мэдээлж байх.
5. Боловсролын салбар дахь холбон зуучлах үйлчилгээг сайжруулахад арга хэмжээ авч ажиллах.
6. Эрүүл мэндийн салбарт хүүхэд хамгааллын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг эмч нарт хүртээмжтэй, тогтмол хүргэж байх.
7. Соёл, спортын үйл ажиллагаа дахь хүүхэд хамгааллыг хуульд заасны дагуу хэрэгжүүлж ажиллах талаар хяналт тавьж ажиллах.
8. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/453 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-д заасны дагуу сургууль, цэцэрлэгүүдэд хийгдсэн гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээгээр илэрсэн эрсдэлийг тухай бүрд нь шийдвэрлүүлэх талаар анхаарч ажиллах.

Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газрын дарга Н.Цэвээндуламд:

1. Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтыг иргэд, олон нийтэд ил тод мэдээлж байх
2. Нэг цэгийн үйлчилгээний төвийн орчин нөхцөлийг сайжруулах, нэг хүүхдэд ногдох хоолны нормативыг засгийн газрын тогтоолыг үндэслэн олгох.
3. Хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, мэдээ, тайланг үнэн, зөв, бодитой илэрхийлэх.
4. Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн мөрөөр арга хэмжээ авч ажиллах.
5. Гэр бүлийн зөрчлийн суурь шалтгааныг сүүлийн 5 жилээр судлан, нарийн дүн шинжилгээ хийж, гэр бүл рүү чиглэсэн урьдчилсан сэргийлэх, нөлөөллийн сургалт, сурталчилгааны хамрагдалтыг нэмэгдүүлэх.

Аймгийн боловсролын газрын дарга Г.Пүрэвдорж-д:

1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/453 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.9-д заасны дагуу ЕБС-уудад хяналт-шинжилгээ үнэлгээг хийж, үр дүнг тооцож ажиллах. /аудитаар илэрсэн алдаа зөрчлүүдэд анхаарах/

2. Дотуур байрны багшийн ажил үүргийг хавсран гүйцэтгүүлэхгүй байх, сургуулиас тавих хяналтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлж ажиллах.
3. Кейс бүртгэлийн маягыг боловсруулан баталж, ЕБС-уудад маягт хөтлөлтийг тогтмолжуулах. /зөрчил, кейс нээсэн, хаасан, шилжүүлсэн зэрэг тэмдэглэгээ г.м/
4. Өндөр эрсдэлтэй хүүхдүүдийг мэргэжлийн байгууллагад холбон зуучлах үйлчилгээг сайжруулахад анхаарч төлөвлөгөө боловсруулж ажиллах.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР





ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар

4/25

Арвайхээр сум

Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.3 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх, үүрэг"-ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан/ ӨВА-2024/20-14-ШТА-ГА/-г нэгдүгээр хавсралтаар, аудитын шалгалтаар тогтоосон албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор хариу мэдэгдэхийг Аймгийн ИТХ-ын дарга /Т.Нарангарав/, Засаг дарга /И.Доржсүрэн/, ХГБХХГ-ын дарга Н.Цэвээндулам, Боловсролын газрын дарга Г.Пүрэвдорж нарт тус тус зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2025 оны 2 дугаар улиралд гаргаж танилцуулахыг аудитын менежер /Д.Гансүх/, гүйцэтгэл-нийцлийн багийн ахлах аудитор /П.Хорлоосүрэн/ нарт үүрэг болгосугай.

4. Тайланг Үндэсний аудитын газар, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Боловсролын газарт тус тус хүргүүлсүгэй.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /П.Хорлоосүрэн/-д үүрэг болгосугай.



О.БАТЖАРГАЛ

015010066

D:\Auditin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal



Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын
газрын 2024 оны 10 дугаар сарын 24-ний А25/тоот
тушаалын хоёрдугаар хавсралт

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Мөнгөн дүн /сая.төг/
1	Хүүхэд хамгааллын зардлаас албан хаагчдын дэмжлэгт 11.2 сая төгрөг, шинэ жилийн бэлэгт 0,9 сая төгрөг, аудитын төлбөрт 0.4 сая төгрөг тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.	377/А1560347/ӨВА-2024/20-14-ШТА-ГА	12.5

D:\Audiitiin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

Монгол улс, Өвөрхангай аймаг
Арвайхээр сум, Нутгийн удирдлагын ордон
Утас: +976 70323253, 70323833, 70323108
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn, цахим хуудас: www.audit.mn